# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (488)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

*Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2007 оны гуравдугаар сарын 15 | №11 (488)


## Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


167. Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай | Дугаар 192 | 261


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 08 дугаар сарын 16-ны өдөр** | **Дугаар 192** | **Улаанбаатар хот**

**Боловсролын салбарын мастер төлөвлөгөөний тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

2. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нарийвчлан тооцон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, нэгдсэн төсөвт тусгуулж хөрөнгө оруулалтыг татан оролцуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин нарт даалгасугай.

3. Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явцыг жил бүрийн 9 дүгээр сарын эхний хагаст багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** — **М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД** — **Н.БАЯРТСАЙХАН**

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД** — **Ө.ЭНХТҮВШИН**

**Засгийн газрын 2006 оны 192 дугаар тогтоолын хавсралт**

## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫГ 2006-2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

### I БҮЛЭГ

### МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төлөвлөгөөний зорилго, үндсэн асуудал

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө нь Засгийн газраас боловсролыг хөгжүүлэх талаар 2015 он хүртэлх хугацаанд баримтлах урт хугацааны стратеги, үндсэн чиглэлийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө нь:

• Хөдөөгийн хүн ам болон нийгмийн зарим хэсэг, бүлгийн боловсрол эзэмших нөхцөл, боломжийн ялгааг зогсоох, улмаар тийм ялгааг арилгах, үүний тулд хөдөөгийн хүн ам, нийгмийн эмзэг бүлгийн боловсрол эзэмших боломжийг улам өргөжүүлэх, боловсролын үйлчилгээг нутаг дэвсгэрийн бүх түвшинд хүртээмжтэй, нэвтрэх боломжтой болгох стратеги үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн дээр ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш бус, ялгаатай байдлыг багасгахад нөлөөлөх

• Боловсролын үйлчилгээг нийгэм, соёлын үнэт зүйлс, итгэл үнэмшил, хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх. "Боловсролын тогтолцооны

бүтэц, сургалтын хөтөлбөр, агуулгыг улам боловсронгуй болгож дэлхийн хөгжингүй орнуудын нийтлэг жишигт хүргэх, эзэмшсэн боловсрол нь эргээд өөрт нь цаашид тасралтгүй суралцах, амьдрах чадвар, амьдралын баталгаа болдог байхаар чанартай боловсролын үйлчилгээг бий болгох, улмаар өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийн чадавхийг бий болгох гэсэн үндсэн асуудлуудад хариу болох бодлого, стратегийн шийдлүүдийг танилцуулж байна.

1.2. Мастер төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчим

Мастер төлөвлөгөө нь:

- Улсын Их Хурлаар 2005 онд баталсан "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт", Засгийн газраас 2003 онд баталсан "Ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах стратеги" зэрэг хүний эрх, хөгжлийг хангах нийгмийн таатай орчинг бүрдүүлэх, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш байдал, тогтвортой хөгжлийг хангах, эдийн засгийн өсөлтийг бий болгоход чиглэгдсэн Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого, стратегид тулгуурлах;

- НҮБ-аас 2000 онд баталсан "Мянганы хөгжлийн зорилт", дэлхийн боловсролын Форумаас 2000 онд Дакарын Сенегалд баталсан "Бүх нийтийн боловсролын Дакарын үйл ажиллагааны хүрээ", НҮБ-аас 2003 онд баталсан "Тогтвортой хөгжлийн төлөө боловсрол-НҮБ-ын арван жил", "Бичиг үсгийн боловсролын НҮБ-ын арван жил" гэх мэт хүний хөгжил, боловсролын талаархи дэлхий дахины зорилт, хүчин чармайлтыг хэрэгжүүлэхэд чиглэх;

- боловсролын талаар хамтран ажиллагч олон улсын хөгжлийн байгууллагууд, иргэний нийгэм, боловсролын үйлчилгээг зохион байгуулагч, түүний үр шимийг хүртэгч зэрэг боловсролд хамааралтай бүх талын оролцоонд тулгуурлан боловсруулах,

- боловсролын хөгжлийн төлөө хөрөнгө оруулагч, хамтран ажилладаг хандивлагч орон, байгууллага, олон улсын хамтын ажиллагааны бүх байгууллагын бодит оролцоо, түншлэл, зөвшилцлийн үндсэн дээр "нэг улс-нэгдмэл бодлого"-ыг бий болгох;

- Засгийн газраас боловсролын салбар дахь бүх хандивлагч орон, байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл байх, нэгдмэл хамтын үйл ажиллагаа уялдуулан зохицуулах үндэс нь болох;

- боловсролын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг бодитоор үнэлж оношлох, боловсролын эрэлтийг оновчтой тодорхойлох, түүнд хариу өгөх чадамж бүхий стратеги, үйл ажиллагааны төлөвлөлтийг тодорхой байдлаар боловсруулах, шаардагдах нөөцийг тооцоолоход салбар дамнасан, үр дүнд чиглэсэн төлөвлөлтийн хандлага, арга барилд үндэслэсэн үнэлгээ, оношилгоо, төлөвлөлт, тооцооны шинжлэх ухааны оновчтой арга зүйг ашиглах;

- бэлэн байгаа хязгаарлагдмал хөрөнгөд тулгуурлан үйл ажиллагаа төлөвлөх бус боловсролын бодит эрэлт, 2015 он гэхэд хүрсэн байх бодлогын зорилтод нийцүүлэн хөгжлийн стратеги, хөрөнгө оруулалтын үндсэн чиглэлийг тодорхойлох;

- олон улсын хөгжлийн байгууллагуудаас 2002 онд баталсан "Монтеррейгийн зөвшилцөл", 2003 онд баталсан "Ромын тунхаглал", 2005 онд баталсан "Парисийн тунхаглал", хандивлагч орон, олон улсын хоёр талт болон олон талт хөгжлийн байгууллагууд, дэлхийн банк хамтран 2003 онд байгуулсан "Хурдан хөгжлийн (замын) санаачилга түншлэл"-ийн хөгжлийн тусламж үзүүлэх үндсэн зарчим гэх мэт олон улсын зээл, тусламжийн уялдуулан зохицуулах, түүний үр ашгийг сайжруулах талаар олон улсын банк, санхүү, хөгжлийн туслалцааны байгууллагуудаас баримталж буй хандлагад нийцүүлэх гэсэн зарчим, хандлагуудад тулгуурлан боловсруулсан.

1.3. Төлөвлөгөөний хамрах хүрээ, хугацаа

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө нь боловсролын салбарыг бүхэлд нь хамарсан төлөвлөлтийн баримт бичиг юм. Төлөвлөгөө нь:

1/ бага насны хүүхдийн боловсрол;

2/ ерөнхий боловсрол (бага, дунд, ахлах);

3/ албан бус, насанд хүрэгчдийн боловсрол;

4/ мэргэжлийн сургалт, техникийн боловсрол;

5/дээд боловсрол;

6/ дэд салбар дундын хүрээний төлөвлөлтүүдийг хамарна.

Мастер төлөвлөгөө 2015 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд дэд салбар бүрийн үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө нь 2010 он хүртэлх таван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн болно.

1.4. Төлөвлөгөөний бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө нь:

1/ боловсролын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал;

2/ бодлогын зорилт, стратеги (2006-2015);

3/ дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх үзүүлэлт;

4/ төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаанд бий болох боловсролын хэрэгцээ, шаардагдах нөөцийн тооцоо;

5/ төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, хяналт-шинжилгээ гэсэн үндсэн таван хэсгээс бүрдэнэ.

## II БҮЛЭГ
## БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

2.1. Нийгэм, эдийн засаг, соёлын өөрчлөлт, боловсролын харилцан хамаарал

Монгол Улс сүүлийн 10 гаруй жилийн турш жилд дунджаар улсын төсвийн зарлагын 5 төгрөг тутмын 1 төгрөгийг боловсролд тогтвортойгоор зарцуулж байгаа бөгөөд боловсролын зардал 1996 онтой харьцуулахад 53 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдсэн байна. Боловсролын хөгжилд оруулах хөгжлийн албан ёсны тусламжийн хэмжээ тогтвортойгоор нэмэгдэж сүүлийн долоон жилийн байдлаар боловсролын албан ёсны тусламжийн хэмжээ нийтдээ 115.7 тэрбум төгрөг хүрсэн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 16.5 хувьтай тэнцэж байна.

Монгол Улс 1990 оноос эхлэн зах зээлийн эдийн засгийн харилцаа бүхий хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн харилцаанд шилжиж эхэлсэн нь боловсролын шинэ тогтолцоог үүсгэн төлөвшүүлэх хүнд сорилтыг авчирсан бөгөөд өнгөрсөн хугацаанд шинэ нийгмийн суурь зарчимд нийцсэн боловсролын шинэ тогтолцоог бүрэлдүүлжээ. Монгол Улсын нийгэм, эдийн засагт гарч буй ахиц дэвшил, боловсролыг эрхэмлэх талаар иргэдийн итгэл, үнэмшил, нийгмийн соёл, үнэт зүйлсийн төлөвшил, төр, засгийн газраас хүн бүр боловсролыг адил тэгш эрхтэйгээр эзэмших эрхийн баталгааг хангахад онцгой анхаарал хандуулж байгаагийн үр дүнд боловсролын бүтэц, тогтолцоо, үйл ажиллагаанд өөрчлөлт шинэчлэлт хийгдэж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашиг жилээс жилд дээшилсээр байна.

2000 оноос эхлэн дотуур байрны хүүхдийн бүх зардлыг төрөөс бүрэн хариуцах, нийгмийн эмзэг бүлгийн өрхийн хүүхдийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх, хичээлийн хэрэглэл, сургуулийн дүрэмт хувцсыг буцалтгүй тусламж болгон олгох, малчин өрхийн нэг хүүхэд, нэн ядуу өрхийн нэг хүүхэд, нэг өрхөөс 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцдаг өрхийн нэг хүүхэд, бүтэн өнчин хүүхэд, тахир дутуу хүүхдийн дээд боловсролын сургалтын төлбөрийг төрөөс хариуцах зэрэг арга хэмжээнүүдийг Засгийн газраас хэрэгжүүлж байгаа нь ядуу болон малчин, эмзэг бүлгийн өрхийн хүүхдийн суралцах адил тэгш эрхийн баталгааг хангах бодит нөхцөлийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг хангаснаар ядуурлыг бууруулах, ядуурлыг бууруулснаар эдийн засгийн өсөлтийг дэмжих стратегийн хүрээнд нийгмийн суурь үйлчилгээг бүх нийтээр тэгш хүртэх боломжийг бий болгох, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг өргөжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна.

Засгийн газар 2004 оноос эхлэн 3 ба түүнээс дээш хүүхэдтэй ядуу өрхийн хүүхэд бүрт сар болгон 3000 төгрөгийн тэтгэлгийг олгох "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийг хэрэгжүүлж, улмаар 2006 оноос эхлэн бүх хүүхдийг энэхүү хөтөлбөрт хамруулах болсон нь ядуу өрхийн амьжиргааны орлогыг нэмэгдүүлэхэд үр дүнгээ өгч эхэлснийг судалгааны эх сурвалжууд нотолж байна. Сургуулийн насны хүүхэд сургуульд суралцдаг тохиолдолд мөнгөн тэтгэлгийг олгож байгаа нь ядуу өрхийн хүүхдийн сургуульд хамрагдалтыг мэдэгдэхүйцээр нэмэгдүүлж эхлээд байна .

Дотоодын шилжилт хөдөлгөөн бий болсон нь нэгэнт ачааллаа даахгүй байгаа Улаанбаатар хот болон суурин газруудад нэмэлт бэрхшээлийг бий болгож шилжин ирэгсдийн голомт болсон хот, суурин газруудын сургуулиуд 3 ээлжээр ажиллах, нэг ангид 40-50 гаруй хүүхэд хичээллэх, "харьяаллын бус", "хамран сургах тойргийн бус" хэмээн тодотгогдсон хүүхдүүд шилжин ирсэн газрын сургуульдаа ачаалал хэтэрсний улмаас гэдэг шалтгаанаар суралцаж чадахгүй байх, завсардах бэрхшээлүүд үүсэн бий болоод байна.

Шилжин явагсад олон байгаа хөдөө, орон нутагт амьдардаг хүмүүсийн 30 орчим хувь нь ойрын жилүүдэд төв рүү нүүх төлөвлөгөөтэй байгаа нь боловсролын бодлого, төлөвлөлтөд дотоодын шилжилт хөдөлгөөний хүчин зүйлийг зайлшгүй тооцож үзэх шаардлагатай болоод байна. Дотоодын шилжилт хөдөлгөөн өсөх, буурах нь

ядуурал, ажилгүйдлийг бууруулах, нийгэм, эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх үндэсний стратегийн хэрэгжилт, нутаг дэвсгэрийн нэгж, нутгийн удирдлага, засаг захиргааны нэгжийн шинэчлэл зэрэг нийгэм, эдийн засгийн макро түвшний үйл ажиллагаанаас шууд хамааралтай боловч шилжин нүүгчдийн гуравны нэг орчим нь хүүхдээ чанартай сургуульд суралцуулах, хүүхдийнхээ ирээдүйн төлөө нүүж байгаа нь дотоодын шилжилт, хөдөлгөөнийг боловсролын бодлого, төлөвлөлтөөр дамжуулан саармагжуулах онцгой үүрэг ногдуулж байна.

Хөдөөгийн сургуулиудыг дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн амьдрах, суралцах орчинг байнга сайжруулж байх, сургалтын чанарын түвшинг бууруулахгүйгээр багийн бага сургууль, холимог бүлгийн сургалтыг дэмжих нь малчдын сургуулийн насны хүүхдийн суралцах эрхийн баталгааг хангах, хөдөөгийн амьдрал, соёлын өвөрмөц онцлогт нийцсэн стратеги болж байна. Өнөөгийн байдлаар бага насны нийт хүүхдийн 25.0 орчим хувь буюу 4 хүүхэд тутмын 1 нь малчдын бага насны хүүхэд байгаа боловч малчдын амьдралын хэв маягт нийцсэн төрийн дэмжлэгтэй цэцэрлэгийн бус сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний асуудал шийдэгдээгүй хэвээр байна.

Хөдөөгийн хүн амын суурьшлын нягтрал бага, тархай бутархай байдлын онцлог нь зарим тохиолдолд одоо мөрдөж байгаа боловсролын санхүүжилтийн норм, нормативтай зөрчилдөх, бага оврын, хүчин чадлын ашиглалт өндөр, санхүүжилтийн хувьд үр ашигтай цэцэрлэг, сургуулийн барилгын стандартыг шинээр тогтоох зэрэг асуудлуудыг үүсгээд байна.

Монгол Улс 2004 оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулийг дэлхий нийтийн жишиг, чиг хандлагад нийцүүлэн 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлсэн бөгөөд улмаар ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих гэж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжихтэй холбоотойгоор боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, агуулгын шинэчлэлийг үргэлжлүүлэх, сурах бичгийг шинэчлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийг компьютержүүлэх, сургалтад мэдээлэл, холбооны технологийг нэвтрүүлэх, багш нарыг давтан бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, бага ангийн хүүхдүүдэд өдрийн цай, хоол өгөх асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг ойрын жилүүдэд шийдвэрлэх шаардлага бий болж байна.

Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны хэрэгцээний 60-70 хувийг мэргэжилтэй ажилчны захиалга эзэлж байна. Гэтэл 2004 оны байдлаар дээд боловсролын болон мэргэжлийн боловсролын сургуулийн нийт төгсөгчдийн 71.4 хувь нь их, дээд сургууль, 28.6 хувь нь мэргэжлийн сургалт, техникийн боловсролын сургуулийг төгсчээ. Сургууль төгсөгчдийн мэргэжлийн чиглэлийг авч үзэхэд 59.0 хувь нь эрх зүй, сэтгүүлч, эдийн засаг, санхүү зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт, 3.0 хувь нь хөдөө аж ахуйн салбарт хамаарч байгаа бол манай улсын эдийн засгийн бүтцийн 23.3 хувийг хөдөө аж ахуй, 50.1 хувийг үйлчилгээ, 26.6 хувийг аж үйлдвэрийн салбар бүрдүүлж байна.

Үндэсний мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэж буй өнөөгийн байдал нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, эдийн засгийн бүтэц, онцлогтойгоо тохирохгүй байна. Цаашид мэргэжлийн боловсролын сургуулиудын үйл ажиллагааг үндэсний үйлдвэрлэл, технологийн хөгжлийг дэмжих, үндэсний эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэхэд төрийн оролцоо, зохицуулалтын үүргийг нэмэгдүүлэх, бодлогоор нөлөөлөх стратегийг хэрэгжүүлэх нь боловсролын төдийгүй эдийн засгийн өсөлтийг хангах үндэсний стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болж байна.

Өнөөгийн байдлаар дээд боловсролтой төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 34.8 хувь байна. Мөн их, дээд сургуулийн ахлах курсийн оюутны 34.2 хувь нь сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллахгүй гэсэн сонирхолтой байгаагийн зэрэгцээ ядуу хүн амын бүтцэд дээд боловсролтой иргэд 25.5 хувийг бүрдүүлж байгаа нь анхаарч үзэх асуудал болоод байна. Мэргэжлийн сургалт, техникийн боловсрол, их, дээд сургуулийн бие даасан байдал, чанарын төлөө өрсөлдөөний орчныг бий болгох, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чадавхийг бэхжүүлэх, сургалтын чанарын баталгаа, стандартын хяналтыг боловсронгуй болгох үндсэн дээр мэргэжлийн боловсролын сургалтын чанар, боловсон хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь мэргэжлийн боловсролын талаархи бодлого, төлөвлөлтийн тэргүүлэх зорилтын нэг болж байна.

Үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад боловсролын үүрэг оролцоог бодитойгоор нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага үүсч байна. Нэн ялангуяа мэргэжлийн боловсрол дахь хувийн хэвшлийн оролцоог чанаржуулах, мэргэжлийн сургалт, техникийн боловсрол, их, дээд сургуулиудын сургалт, эрдэм, шинжилгээний материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтад дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, сургалт, эрдэм шинжилгээний судалгаа, үйлдвэрлэлийн уялдаа холбоог сайжруулах, багшлах боловсон хүчин, эрдэм шинжилгээний ажилтнуудын мэргэжлийн чадварыг бэхжүүлэх, мэргэжлийн боловсролын

сургуулийн оюутан, суралцагчдад зориулсан сургалтын төлбөрийн эргэн төлөгдөх зээлийн таатай орчин бүрдүүлэх, хөгжингүй орнуудад оюутан залуучууд суралцах нээлттэй боломжийг улам өргөжүүлэх нь мэргэжлийн боловсролын цаашдын бодлого, төлөвлөлтийн үндсэн стратегийн чиглэлүүд байх болно.

2.2. Боловсролын тулгамдсан асуудлууд

Бага насны хүүхдийн боловсролын талаар:

**Хүртээмж**

1. Малчин өрхийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломж хязгаарлагдмал байна.
2. Ядуу өрхийн хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах тэгш боломж хязгаарлагдмал байна.
3. 0-2 насны хүүхдүүд нийгмийн үйлчилгээ хүртэх боломж хязгаарлагдмал.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээнд хамрагдах тэгш боломж хязгаарлагдмал байна.

**Чанар, нийц**

5. Хоол, тэжээлийн хомсдол цэцэрлэгийн хүүхдүүдэд нүүрлэсээр байна.
6. Цэцэрлэгийн барилгын хүчин чадал нь хот суурин газарт хүрэлцэхгүй байна.
7. Цэцэрлэгийн барилгын нөхцөл байдал, материаллаг орчин нь хүүхдийн эсэн мэнд, эрүүл өсөх, хөгжих, боловсроход шаардагдах хэвийн аюулгүй орчны шаардлагыг хангахгүй байна.
8. Цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүний хангамж хангалтгүй байна.

**Менежмент**

9. Сургуулийн өмнөх боловсролын хүний нөөцийн чадавхийг шинэ хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх үйл явц удаашралтай, хангалтгүй байна.
10. Бага насны хүүхдийн хөгжлийн талаар мэдээлэл, үр дүнд тулгуурласан бодлого, менежмент хийгдэх боломжгүй байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын талаар:

**Хүртээмж**

1. Сургуулийн гадна байгаа 8-15 насны хүүхдийн тоо дорвитой буурахгүй байна.
2. Хүүхдийн сурч боловсрох эрх тэгш боломж бага боловсролын түвшинд илүү ихээр зөрчигдөж байна.
3. Бага, дунд боловсролын үйлчилгээнд хот, хөдөөгийн болон хотын төв, захын хорооллын ялгаа их байна.
4. Суралцагчдын хүйсийн тэнцвэрт байдал алдагдаж байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй, тусгай хэрэгцээт боловсрол шаардсан хүүхдийн суралцах, хөгжих адил тэгш боломж бүрэн хангагдахгүй байна.
6. Хотын сургуулиудын ачаалал ихсэж, хөдөөгийн сургуулиудын ачаалал буурч сургуулийн тогтвортой хөгжлийн бодлого үгүйлэгдэж байна.

**Чанар, нийц**

7. Цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндэсний кирриюлимийн бүрэлдэхүүн хэсгүүд болох сургалтын төлөвлөгөө, агуулгын бүтэцчилсэн хүрээ, сурах бичгийн хангамж, сурлагын амжилтын үнэлгээ зэргийг нь цогцоор боловсруулан туршиж, магадлан итгэмжилж хэрэгжүүлэхэд бэлэн болоогүй байна.
8. Шинэ стандарт, нээлттэй кирриюлимийн хэрэгжилтийг хангахад нийгэм, эдийн засгийн дэмжлэг дутагдаж байна.
9. Шинэ стандарт, нээлттэй кирриюлимийн хэрэгжилтийг хангахад багшийн мэргэжил, арга зүйн цогц дэмжлэг дутагдаж байна.
10. Сурах бичгийн хүртээмж хангалтгүй, шинэ стандартын шаардлагыг хангасан сурах бичиг цөөн байна.
11. Сургалтын тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн хүртээмж хангалтгүй, хөрөнгө оруулалтыг тэгш бус хуваарилж байна
12. Сургуулийн барилгын чанар, дэд бүтэц, цэвэр ус, дулаан, цахилгаан хангамж ялгаатай байгаагаас хүүхдүүд ээлтэй, тэгш боломжоор суралцаж чадахгүй байна.
13. Сурлагын амжилтын үнэлгээ нь хүүхдийн суралцах сонирхол, идэвхийг дэмжих, боловсролын стандарт, кирриюлимийн хэрэгжилтийг үнэлэх болон боловсролын үйлчилгээг боловсронгуй болгоход чиглэгдэж чадахгүй байна.

**Менежмент**

14. Бодлого, эрх зүйн орчин нь сургууль, байгууллагын хөгжлийг дэмжиж чадахгүй байна.
15. Бодлого, төлөвлөлт, менежмент нь мэдээлэлд тулгуурлаж, үр дүнд чиглэгдэж чадахгүй байна.
16. Чанарыг баримжаалсан шинэ зорилго ба тоог баримжаалсан хуучин үнэлгээний барил хоорондын зөрчил байсаар байна.

<u>Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар</u>:

**Хүртээмж**

1. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамран сургалт хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлтийг хангаж чадахгүй байна.

**Чанар, нийц**

2. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын төгсөгчид мэргэжлийн ажилтанд тавигдах шаардлагыг хангахгүй байна.
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, агуулга зах зээлийн эрэлтэд нийцэхгүй, сургалтын арга зүй шинэчлэгдээгүй байна
4. Багшийн хангамж, мэргэжлийн бэлтгэл, нийгмийн байдал сул байна.
5. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамж байхгүй, сургалтын орчин муу байна.
6. Чанарын хяналтын үндэсний тогтолцоо хөгжөөгүй байна.

**Менежмент**

7. Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын бодлого, эрх зүйн орчин нь мэргэжлийн сургалтын үйлчилгээг зах зээлийн эрэлттэй нийцүүлж чадахгүй байна.
8. Мэргэжлийн боловсрол, сургалтын санхүүжилт хязгаарлагдмал байна.
9. Мэргэжлийн сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндэсний болон орон нутаг, сургуулийн мэргэжлийн удирдлагын чадавхи сул байна.

<u>Албан бус болон насанд хүрэгчдийн боловсролын талаар</u>:

**Хүртээмж**

1. Бичиг үсэг үл мэдэгч, шинээр тайлагдагсдад зориулсан албан бус боловсролын хүртээмж хязгаарлагдмал байна.
2. Сургуулийн гадна буй хүүхэд, залуус албан бус боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж хангалтгүй байна.
3. Насанд хүрэгчдийн сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон, тасралтгүй боловсролын үйлчилгээ жигд бус байна.

**Чанар, нийц**

4. АББ-ын сургалтын орчин бүх түвшинд зохих хэмжээнд хүрээгүй байна.
5. АББ-ын байгууллагуудын чадавхи бүх түвшинд сул, ялангуяа хүний нөөц, боловсон хүчин дутмаг байна.
6. АББ ба насанд хүрэгчдийн боловсролын салбарын сургалтын агуулга, арга зүй бүрэн боловсруулагдаагүй, сургалтын хэрэглэгдэхүүний хүрэлцээ муу байна.
7. Албан бус болон нээлттэй хэлбэрээр бага, суурь боловсрол эзэмших сургалтын чанар хангалтгүй, түүнийг үнэлэх тогтолцоо сул байна.

**Менежмент**

8. АББ-ын салбарын өнөөгийн бодлого, стратеги нь нийт хүн амд тасралтгүй, насан туршдаа суралцах боломжийг хангалттайгаар бүрдүүлж чадахгүй байна.
9. АББ-ын салбарт мэдээллийн тогтолцоо бүрдээгүй, тодорхой аргачлалгүй, мэдээллийг цуглуулах, боловсруулах, солилцох, ашиглах явдал хангалтгүй байна.
10. АББ-ын салбарын санхүүжилтийн механизм тогтвортой бус, тодорхой болоогүй байна.

<u>Дээд боловсролын талаар</u>:

**Хүртээмж**

1. Дээд боловсролын хамран сургалтын өсөлтөд бодит бус хүчин зүйлийн нөлөөлөл их байна.

| | |
|---|---|
| Чанар, нийц | 2. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалт судалгааны ажил, сургалтын орчинд тавих стандартын иж бүрэн тогтолцоо бүрдээгүй байна.<br>3. Дээд боловсролын багшийн хангамж, мэргэжлийн бэлтгэл сул байна |
| Менежмент | 4. Дээд боловсролын удирдлага зохицуулалт сул байна.<br>5. Оюутанд үзүүлэх зээл, тусламжийн одоогийн тогтолцоо нь үр ашиггүй зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна. |

## III БҮЛЭГ

## МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, СТРАТЕГИУД (2015 ОН ХҮРТЭЛ)

3.1. Боловсролын салбарын хэтийн болон эрхэм зорилго

ҮНЭТ ЗҮЙЛС

1. Чанар
2. Тэгш байдал
3. Нийгмийн оролцоо

ХЭТИЙН ЗОРИЛГО

Боловсролын салбарын хэтийн зорилго нь боловсролжсон иргэний нийгмийн тасралтгүй баяжиж буй соёлоор дамжин Монгол Улсын тогтвортой хөгжлийн эх сурвалж, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын найдвартай баталгааг хангахад чиглэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Боловсролын салбарын эрхэм зорилго нь Монгол Улсын иргэн бүр хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд чинээлэг сайхан амьдрахын тулд өөрийн чадавхийг бүрэн илрүүлэн хөгжих, асуудлыг шийдвэрлэх, бүтээлчээр ажиллахад нь шаардагдах мэдлэг, чадвар, технологи болон соёлын үнэт зүйлсийг эзэмших, сонгох тэгш боломж, таатай орчин төлөвшүүлэн, байнга сайжруулахад чиглэсэн хүртээмжтэй, чанартай, үр ашигтай, тогтвортой үйлчилгээг үзүүлэхэд чиглэнэ.

3.2. Мастер төлөвлөгөөний тэргүүлэх чиглэлүүд

1. Бүх иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжгүй байдлыг багасгах, арилгах, тэдний суралцах эрхийг хангахад төрөөс баримтлах нийгмийн хамгаалал болон нийгмийн халамжийн бодлогын хүрээнд суралцагч-хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх

2. Иргэдэд тасралтгүй суралцан, чанартай ажиллаж, амьдрах, сонголт хийх, авьяасаа илрүүлэн хөгжүүлэх эрэлт хэрэгцээг нь хангахуйц түвшний боловсролын стандарт, кирриюлимийг шинэчлэн, тэдгээрийг хэрэгжүүлэх нийлүүлэлтэд мөрдөх стандарт, бодлого, стратеги, дүрэм журмыг цогцоор нь шинэчлэн мөрдөх

3. Суралцагч, багш, ажилтнуудыг стандартын шаардлага хангасан суралцах, ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, боловсролын чанартай үйлчилгээг тэгш хүртэх боломжоор хангахын тулд хөрөнгө, төсөв санхүү, технологийн нөөцийг бүрдүүлэх, зохистой хуваарилах, зарцуулах, хянах, мэдээлэх удирдлагыг шинэчлэх

4. Нийгмийн хөгжилд үзүүлэх салбарын тэргүүлэх байр суурь, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ажлын агуулга, арга зүйн өөрчлөлтийн мөн чанар, хэмжээнд нь тохирсон мэргэжил арга зүйн хөгжлийн болон цалин хөлс, урамшил, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хүний нөөцийн хөгжилд хүчтэй хөрөнгө оруулалт хийх

5. Боловсролын бүх байгууллага, сургууль, цэцэрлэгийг интернеттэй холбосноор сургалт, мэдээлэл солилцоо, хяналт-шинжилгээ, үнэлгээ, бүртгэл тооцооны мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх

6. Боловсролын захиргаа, мэргэжлийн удирдлагын тогтолцоог нэгж, байгууллага, орон нутаг, үндэсний түвшинд шийдвэр гаргах эрх мэдлийн төвлөрлийн сааруулалт, шилжүүлэлт, сийрэгжүүлэлтийн оновчтой хуваарилалттай, эрх мэдэл, үүрэг хариуцлага, өс зүйн зохистой шүтэлцээтэй, ил тод хяналттай болгон шинэчилж, байгууллагын хөгжлийг дэмжиж, сургуульд суурилсан удирдлагыг хөгжүүлэх

7. Гадаадын болон дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон улсын төрөлжсөн болон санхүүгийн байгууллагуудын идэвхтэй, бүтээлч оролцоог хангах замаар боловсролын чанар, хүртээмж, тэгш байдлыг цогцоор нь эрэмбэ ахиулан шинэчлэхэд шаардлагатай техник, технологи, хөрөнгө, санхүү, хүн, нөөцийг бүрдүүлэх, тэдэнтэй үр өгөөжтэй хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгох.

### 3.3. Боловсролын салбарын зорилго, стратеги

#### Бага насны хүүхдийн боловсролын зорилго, стратеги (2006-2015 он)

| | Зорилго | Хэрэгжүүлэх арга зам, стратеги |
|---|---|---|
| 1. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 99.0 хувьд хүргэх | • Хүн амын суурьшил, нягтрал, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулан шаардлагатай газарт цэцэрлэгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр цэцэрлэг барих<br>• Нүүдлийн амьдралын хэв маягт нийцсэн, гэр бүлд тулгуурласан тохиромжтой, хүртээмжтэй зохион байгуулалттай үйлчилгээг бий болгох<br>• Нийгмийн эмзэг бүлгийн (ядуу, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин ирэгсэд гэх мэт) хүүхдүүдийг адил тэгш боломжтойгоор хамруулах ялгаатай, тэнцүүлэх бодлогыг хэрэгжүүлэх<br>• Хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд цэцэрлэгийн бус арга хэлбэрээр хамруулах, сургуульд бэлтгэх сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулах<br>• Сургуульд бэлтгэх олон хувилбартай, тохиромжтой үйлчилгээг хэрэгжүүлэх санхүүжилтийн баталгаа, эрх зүйн орчинг бий болгох |

| | | |
|---|---|---|
| 2. | Бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай боловсролын үйлчилгээг бий болгох | • Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнс, ундны цэвэр усны хангамжийг сайжруулах<br>• Хөгжлийн цогц стандартыг боловсруулж нэвтрүүлэх үндсэн дээр бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангах нийгмийн үйлчилгээний үндсийг бий болгох<br>• Цэцэрлэгийн барилгын болон сургалтын орчны стандартыг боловсруулан баталгаажуулж, мөрдүүлэх<br>• Сургуулийн өмнөх боловсролын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, тэдний нийгмийн асуудлыг үе шаттайгаар дээшлүүлэх<br>• Сургуулийн өмнөх боловсролын сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлэх |
| 3. | Бага насны хүүхдийн үйлчилгээний талаарх бодлого, эрх зүй, менежментийг боловсронгуй болгох | • Хувийн хэвшил, иргэний нийгмийн зүгээс бага насны хүүхдийн үйлчилгээг эрхлэх сонирхол, хэрэгцээг дэмжсэн бодлого, эрх зүй, зохицуулалтын таатай орчин бий болгоход төрөөс дэмжлэг үзүүлэх<br>• Бага насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, нийгмийн халамж, хамгааллын асуудлыг хариуцсан яамдын ажил үүргийн уялдаа холбоог хангах |

Бага, дунд боловсролын зорилго, стратеги
(2006-2015 он)

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга зам, стратеги |
|---|---|---|
| 1. | Суралцагчдад чанартай боловсрол эзэмших тэгш боломжгүй байдлыг багасгах, суралцах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх | • Амьдарч, суралцаж байгаа газар нутаг, эцэг эхийнх нь эрхлэж байгаа ажил хөдөлмөрийн онцлог болон өрхийн амьжиргааны түвшин, эзэмших боловсролын хэрэгцээний ялгааны хамаарлыг багасгах<br>• Суралцах эрх нь зөрчигдөж буй хүүхдэд суралцах тэгш боломжийг бүрдүүлэх ялгаатай, тэнцүүлэх бодлогыг хэрэгжүүлэх |
| 2 | Бага, дунд боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх | • Хичээлийн болон дотуур байрны барилга, тэдгээрийн тавилга хэрэгсэл, сургалтын кабинет, лаборатори, тоног төхөөрөмж, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлага, стандартыг шинэчлэн боловсруулж жендер, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан тохь тухтай орчинг бүрдүүлэх<br>• Багш, удирдах ажилтныг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх тогтолцоог шинэчлэх, цалин хөлс, нийгмийн хамгааллын бодлогоор багшийн ажиллаж, амьдрах тэгш боломжийг хангах<br>• Сурлагын амжилтын үнэлгээг хүүхдийн суралцах сонирхол, идэвхийг дэмжих, боловсролын стандарт, киррикюлимийн хэрэгжилтийг үнэлэх болон боловсролын үйлчилгээг боловсронгуй болгоход чиглүүлж өөрчлөх |
| 3 | Сургуулийг дэмжих бодлого, менежментийг боловсронгуй болгож хөгжүүлэх | • Сургууль, байгууллагын хөгжлийг дэмжсэн бодлого, эрх зүй, зохицуулалтын таатай орчин бий болгох, төрөөс дэмжлэг үзүүлэх<br>• Мэдээлэлд суурилсан төлөвлөлт, менежментийг хөгжүүлэх<br>• Боловсролд сонирхогч талуудын оролцоо, дэмжлэгийг өргөжүүлэх, зохицуулах |

Албан бус, насанд хүрэгчдийн боловсролын зорилго, стратеги
(2006-2015 он)

| | Зорилго | Хэрэгжүүлэх арга зам, стратеги |
|---|---|---|
| 1. | Албан бус боловсролын үйлчилгээг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх | • Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээнд тохирсон уян хатан үйлчилгээний хүрээг өргөжүүлэх<br>• Насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролын эрх зүйн орчинг бүрдүүлж, бодлогын зохицуулалт хийх<br>• Суурь боловсролыг хугацаандаа эзэмшиж чадаагүй залуучуудад боловсрол нөхөн олгох боломжийг бий болгох<br>• Ядуу, эмзэг бүлгийнхэн, ажилгүйчүүдийн боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, мэргэжил олгох, хөдөлмөр эрхлэх мэргэжлийн дадал олгох, өрхийн орлого нэмэгдүүлэх эх үүсвэр олоход чиглэгдсэн сургалтыг төрийн дэмжлэгтэйгээр явуулах |
| 2. | АББ-ын бүх түвшинд сургалтын орчин, чанарыг сайжруулж, нөөцийн чадавхийг дээшлүүлэх | • АББ-ын Гэгээрлийн төвүүдийн хүчин чадал, нөөцийг нэмэгдүүлэх замаар сургалтын орчинг сайжруулах<br>• Албан бус боловсролын үндэсний болон орон нутгийн чадавхийг бэхжүүлэх |
| 3. | АББ-ын салбарын бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээллийн болон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх | • Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудаас АББ-ын чиглэлээр сургалт, үйлчилгээ зохион байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлэх боломжийг өргөтгөх<br>• Удирдлага, мэдээллийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээний систем бий болгох, мэдээлэлд тулгуурласан АББ-ын бодлого, төлөвлөлт, менежментийн тогтолцоог бий болгох<br>• Албан бус боловсролын санхүүжилтийн бодлогыг тодорхойлох, санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг хянах тогтолцоог бий болгох |

Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын зорилго, стратеги
(2006-2015 он)

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга зам, стратеги |
|---|---|---|
| 1. | Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хамран сургалтыг 56.1 хувиар нэмэгдүүлнэ | ▪ МСТБ олгодог сургуулиудыг нэмэгдүүлэх<br>▪ МСҮТ-ийн үйлчилгээний төрөл, хүрээг өргөжүүлэх<br>▪ МСТБ-ын суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх<br>▪ МСҮТ-ийн ашиглалт, хүчин чадлыг нэмэгдүүлэх<br>▪ Бүсчилсэн хөгжлийн үндэсний стратеги, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулан МСҮТ-ийг шинээр байгуулахыг дэмжих |
| 2. | Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын сургалтын чанарыг сайжруулах, хөдөлмөрийн зах зээл дэх мэргэжилтэй ажиллах хүчний хэрэгцээг хангахуйц нийлүүлэлтийг бий болгох | ▪ МСТБ-ын агуулга, стандартыг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн шинэчлэх<br>▪ МСТБ-ын багшийн хангамж, мэргэжлийн чадавхи, ур чадварыг хөгжүүлэх<br>▪ МСТБ-ын мэргэжлийн хичээлийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх<br>▪ МСҮТ-ийн дадлагын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх<br>▪ Сургалт, үйлдвэрлэлийн уялдаа холбоог сайжруулах<br>▪ МСТБ-ын сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн чадавхийг бэхжүүлэх, чанарын хяналтын тогтолцоог бий болгох |

| | | |
|---|---|---|
| 3. | Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын менежментийг шинэчлэх | ▪ Мэргэжлийн боловсрол,сургалтын санхүү, удирдлага, сургалтын харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох<br>▪ МСТБ-ын нийгмийн түншлэлийн удирдлагыг бий болгох<br>▪ Мэргэжлийн боловсрол, сургалтын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх<br>▪ МСТБ-д гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого, эрх зүйн таатай орчин бий болгох<br>▪ МСТБ-ын үндэсний болон сургуулийн удирдлагыг бэхжүүлэх |

Дээд боловсролын зорилго, стратеги
(2006-2015 он)

| № | Зорилго | Хэрэгжүүлэх арга зам, стратеги |
|---|---|---|
| 1. | Дээд боловсролын хамран сургалтын зохицуулалтыг сайжруулах | • Их, дээд сургуулиудын үйлчилгээний хүрээг өргөжүүлж, нээлттэй болгох<br>• Их, дээд сургуулиудын үйл ажиллагааг үндэсний эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцүүлэх<br>• Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг дэмжих |
| 2. | Дээд боловсролын сургалтын чанарын баталгааг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх | • Дээд боловсролын сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгох<br>• Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг олон улсын стандартад нийцүүлэх<br>• Их, дээд сургуульд багшлах хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх<br>• Дээд боловсролын сургалтын чанарын хяналтыг сайжруулах, чанараар өрсөлдөх эрх зүйн орчинг бий болгох<br>• Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн баазыг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх<br>• Суралцагчдын нийгмийн хамгаалал, суралцах боломжийг өргөжүүлэх бодлогын таатай орчин бүрдүүлэх |
| 3. | Дээд боловсролын удирдлага, санхүүгийн тогтолцоог оновчтой болгох | • Дээд боловсролын удирдлага, санхүүжилт болон төрийн зээлийн тогтолцооны эрх зүйн орчинг сайжруулах<br>• Дээд боловсролын менежментийн чадавхийг бэхжүүлэх |

3.4. Боловсролын дэд салбаруудын товлосон зорилтууд
(2006-2015 он)

Бага насны хүүхдийн боловсролын талаар

Хамран сургалт:

▪ Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 52.9 хувиар нэмэгдүүлж 99.0 хувьд хүргэнэ.

| | 2004 - 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| СӨБ-ын хамран сургалтын хувь /бохир жингээр/ | 46.1% | 63.4% | 99.0% | 99.0% | 99.0% |

Үүнээс:

➢ Хотын хүүхдийн 85.0 хувийг цэцэрлэгт, 14.0 хувийг сургуулийн өмнөх боловсролын бусад хэлбэрийн сургалтад хамруулна.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хотын хүүхдийн хамрагдалт: Цэцэрлэгт | 85% | 4 | 9.7% | 58.7% | 64.4% | 85.0% | 85.0% | 85.0% |
| СӨБ-ын бусад хэлбэрийн сургалтад | 14% | 4 | -4.6% | 16.9% | 16.1% | 14.0% | 14.0% | 14.0% |

- Хөдөөгийн хүүхдийн 35.0 хувийг цэцэрлэгт, 64.0 хувийг сургуулийн өмнөх боловсролын бусад хэлбэрийн сургалтад хамруулна.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөдөөгийн хүүхдийн хамрагдалт: | | | | | | | | |
| Цэцэрлэгт | 35% | 4 | 3.8% | 30.2% | 31.3% | 35.0% | 35.0% | 35.0% |
| СӨБ-ын бусад хэлбэрийн сургалтад | 64% | 4 | 64.7% | 8.7% | 14.3% | 64.0% | 64.0% | 64.0% |

- Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жинг хотод 26.3 хувиар нэмэгдүүлж 85 хувьд, хөдөөд 4.8 хувиар нэмэгдүүлж 35 хувьд хүргэнэ.
- Сургуулийн өмнөх боловсролын бусад хэлбэрийн сургалтыг хотод 2.9 хувиар бууруулж 14.0 хувьд, хөдөөд 55.3 хувиар нэмэгдүүлж 64.0 хувьд хүргэнэ.
- Хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа нийт хүүхдийн эзлэх хувийг 2005 оны түвшнээс 6.2 хувиар нэмэгдүүлж 10 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдагчдын эзлэх хувь | 10.0% | 11 | 9.2% | 3.8% | 4.2% | 5.4% | 6.5% | 10.0% |

Чанар, нийц:

Цэцэрлэгийн хоолны зардлыг бага насны хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээлийн нормд тулгуурлан тогтооно. 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хоолны жилийн нормыг 61.1 (нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 300.0 төгрөг байсныг 484.0 төгрөг болгоно) хувиар өсгөж 116.000 төгрөгөөр тооцож санхүүжүүлнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын жилийн норм (мянган төгрөг) | 116.0 | 2 | 38.2% | 60.8 | 83.9 | 116.0 | 135.3 | 198.8 |

- Хүүхдийн цэцэрлэгийн 8.000 суудалтай барилга, өргөтгөлийг шинээр барина.

| | Зорилт | Товлосон жил | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Шинээр барих барилга, өргөтгөлийн ор/суудлын тоо | 8030 | 10 | 150 | 2770 | 1460 | 3650 |

- Нэг багшид ногдох хүүхдийг 13.2-оос 11.6-д хүргэнэ.

| | 2004 - 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Багш хүүхдийн харьцаа | 13.2 | 12.8 | 11.7 | 11.6 | 11.6 |

- Бүлэг дүүргэлтийг 27.5-аас 25.0-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүлэг дүүргэлт | 25 | 4 | -62.5% | 27.5 | 26.9 | 25.0 | 25.0 | 25.0 |

- Цэцэрлэгийн үндсэн багшийг 100 хувь мэргэжлийн багшаар хангана.
- Цэцэрлэгийн нийт багш нарт эзлэх хувийн цэцэрлэгийн багш нарыг 5.1 хувиар нэмэгдүүлж 10.0 хувьд хүргэнэ.
- 2008-2009 оны хичээлийн жил гэхэд нийт цэцэрлэгийг 100.0 хувь туслах багшаар хангана.
- Сургуулийн өмнөх боловсролын нийт багш нарын 10.0 хүртэлх хувийг хувийн цэцэрлэгийн багш нар бүрдүүлнэ.

| | Зорилт | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн нийт багшид хувийн цэцэрлэгийн багш нарын эзлэх хувь | 10.0% | 4.9% | 5.2% | 6.4% | 6.8% | 10.0% |

- Жил бүр сургуулийн өмнөх боловсролын багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.
- Сургуулийн өмнөх боловсролын хүүхэд, багш нарт зориулсан сургалтын гарын авлага, материалын хангамжийг нэмэгдүүлнэ.
- Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг жил бүр 8.0 хувиар өсгөнө.

| | Зорилт | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Цэцэрлэгийн тоглоом наадгай, тоног төхөөрөмжийн санхүүжилт | 1,220,737 | 8.0% | 67,905 | 73,337 | 257,129 | 207,531 | 682,739 |

- Жил бүр 30 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулна.

Менежмент:

- Бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг эрхэлж буй салбарын яамд, байгууллагуудын нэгдмэл хамтын үйл ажиллагааны менежмент бий болсон байна.
- Бага насны хүүхдийн үйлчилгээний талаар салбар дундын мэдээллийн бааз, нэгдсэн сүлжээ байгуулагдсан байна.

Ерөнхий боловсролын талаар

Хамран сургалт:

- 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн 1, 2 дугаар ангийн хүүхдүүдэд өдрийн цай, хоол өгнө.
- 2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хамрагдалтыг 2.1 дахин нэмэгдүүлнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| ЕБС-ийн дотуур байрны суралцагчдын тоо | 37983 | 40761 | 50376 | 58015 | 82573 |

- Дотуур байранд хамрагдах малчдын хүүхдийн хамран сургалтыг 40.5 хувиар нэмэгдүүлж 75.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үүнээс хөдөөгийн малчдын хүүхдийн эзлэх хувь | 75.0% | 11 | 7.3% | 34.5% | 37.0% | 45.8% | 52.7% | 75.0% |

- Бага боловсролын хамран сургалтын бохир жинг 97.8 хувьд хүргэнэ.
- Дунд ангийн хамран сургалтын бохир жинг 93.4 хувьд хүргэнэ.
- Суурь боловсролын хамран сургалтын бохир жинг 95.6 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Бага боловсролын хамран сургалтын бохир жин | 114.7% | 100.9% | 96.2% | 99.1% | 97.8% |
| Ерөнхий боловсролын дунд ангийн хамран сургалтын бохир жин | 93.4% | 89.0% | 99.5% | 97.2% | 93.4% |
| Суурь боловсролын хамран сургалтын бохир жин | 103.3% | 95.2% | 97.7% | 98.3% | 95.6% |

- Хувийн сургуулиудын оролцоог нэмэгдүүлж, бага боловсрол, дунд анги, ахлах ангийн түвшин тус бүрт нийт суралцагчдын 10.0 хүртэлх хувийг хувийн сургуулиудад хамруулна.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ерөнхий боловсролын хувийн сургуульд суралцагчид (%) | | | | | | | | |
| Бага ангид | 10.0% | 4 | 34.0% | 3.1% | 4.2% | 10.0% | 10.0% | 10.0% |
| Дунд ангид | 10.0% | 4 | 38.9% | 2.69% | 3.7% | 10.0% | 10.0% | 10.0% |
| Ахлах ангид | 10.0% | 11 | 6.2% | 5.19% | 5.5% | 6.6% | 7.4% | 10.0% |

- Ерөнхий боловсролын сургуулиас завсардагчдыг 2005 оны түвшнээс 75.5 хувиар бууруулж 15.5 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| ЕБС-иас завсардсан сурагчдын тоог бууруулах хувь | 100.0% | 71.3% | 48.1% | 32.2% | 15.5% |

- Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдын 20.0 хувийг эхний жилд, дараагийн жилд нь 40.0 хувийг нь сургуульд буцаан оруулна.

| | Зорилт | Товлосон жил | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Завсардагчдаас сургуульдаа буцан орох сурагчдын тоо | 20.0% | 40.0% | 5416 | 3976 | 2925 | 1301 |

- Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдын 40 хувийг албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно.

| | Зорилт | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| АББ, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчид | 40% | 564 | 531 | 370 | 126 |

<u>Чанар, нийц</u>:

- Ерөнхий боловсролын сургуулийн 72.3 мянган суудалтай шинэ барилга, өргөтгөл, 5.2 мянган ортой дотуур байрыг барина.

| | Зорилт | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| ЕБС-ийн хичээлийн байрны шинээр баригдах барилга, өргөтгөлийн суудлын тоо | 72279 | 2672 | 23394 | 9825 | 36388 |
| ЕБС-ийн дотуур байрны шинээр баригдах барилга, өргөтгөлийн орны тоо | 5200 | 200 | 1500 | 1000 | 2500 |

- Ерөнхий боловсролын сургуульд сурч буй эмзэг бүлгийн сурагчдад хичээлийн сурах бичгийг үнэ төлбөргүй эзэмшүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн компьютержүүлэлтийг эрс нэмэгдүүлнэ. Үүнд: Бага боловсролын хүүхэд компьютерийн харьцааг 1250-иас 250 (250 хүүхдэд нэг компьютер), дунд ангийн хүүхэд компьютерийн харьцааг 250-иас 50, ахлах ангийн хүүхэд компьютерийн харьцааг 25-аас 5-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сурагч компьютерийн харьцаа | | | | | | | | |
| Бага боловсрол | 250 | 11 | -13.6% | 1250 | 1000 | 696 | 520 | 250 |
| ЕБС-ийн дунд анги | 50 | 11 | -13.6% | 250 | 216 | 139 | 104 | 50 |
| ЕБС-ийн ахлах анги | 5 | 11 | -13.6% | 25 | 22 | 14 | 10 | 5 |

- Бага болвсролын багш нарын 10.0 хувь, дунд, ахлах ангийн багш нарын 15.0 хүртэлх хувийг хувийн сургуулийн багш нар бүрдүүлнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага боловсролын нийт багшид хувийн сургуулийн багшийн эзлэх хувь | 10.0% | 4 | 19.2% | 5.0% | 5.9% | 10.0% | 10.0% | 10.0% |
| Ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн нийт багшид хувийн сургуулийн багшийн эзлэх хувь | 15.0% | 4 | 19.7% | 7.3% | 8.7% | 15.0% | 15.0% | 15.0% |

- Суурь боловсрол амжилттай төгсөгчдийн хувийг 99.5 хувьд хүргэнэ.
- Ахлах ангийг амжилттай төгсөгчдийн хувийг 99.9 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Суурь боловсрол эзэмшин төгсөгчдийн хувь | 99.5% | 4 | 1.2% | 95.0% | 96.1% | 99.5% | 99.5% | 99.5% |
| Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн хувь | 99.9% | 4 | 0.2% | 99.0% | 99.2% | 99.9% | 99.9% | 99.9% |

- Ерөнхий боловсролын сургуулийн улирагчдыг 2005 оны түвшнээс 60.0 хувиар бууруулж 40.0 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Ерөнхий боловсролын сургуулийн улирагчдын тоог багасгах хувь | 100% | 104% | 81% | 66% | 40% |

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний санхүүжилтийг жил бүр 8 хувиар нэмэгдүүлнэ.
- Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бүр хичээл бүрийн нэг сурах бичиг, багш бүр заадаг хичээлийнхээ багшийн гарын авлагатай байна.
- Жил бүр ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.
- Жил бүр 200 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулна.
- Хүүхдийн сурлагын амжилтын үнэлгээ, багш, сургуулийн ажлыг дүгнэх үнэлгээний тогтолцоог хүүхдэд ээлтэй байхаар өөрчилнө.

Менежмент:

- ЕБС-ийн байршил, бүтэц, хэв шинжийг тогтоох стратегийн бодлого, төлөвлөлт бий болсон байна.
- Боловсролын удирдлага, мэдээллийн бааз, үндэсний систем байгуулагдсан байна.

Бага боловсролын талаар

Хамран сургалт:

- Эмэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 99.6 хувьд, эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 96.1 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жин | 114.6% | 100.6% | 95.4% | 95.2% | 96.1% |
| Эмэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жин | 114.7% | 101.2% | 97.0% | 103.1% | 99.6% |

- Бага боловсролд хамрагдах нийт эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 65 хувийг хотод хамруулна.
- 7 настай хүүхдийн 99.9 хувийг 2005-2006 оны хичээлийн жилд, 6 настай хүүхдийн 99.9 хувийг 2008 он гэхэд сургуульд бүрэн элсүүлнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 настай хүүхдийн сургуульд элсэх хувь | 99.9% | 4 | 50.6% | 15.4% | 26.2% | 99.9% | 99.9% | 99.9% |
| 7 настай хүүхдийн сургуульд элсэх хувь | 99.9% | 1 | 25.1% | 79.9% | 99.9% | 99.9% | 99.9% | 99.9% |

- Эмэгтэй, эрэгтэй хүүхдийн элсэлтийн бохир жинг 94.0 хувьд хүргэнэ.

| | 2004, 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Элсэлтийн бохир жин: | | | | | |
| Эрэгтэй | 148.8% | 142.9% | 138.0% | 107.1% | 94.0% |
| Эмэгтэй | 147.7% | 142.5% | 139.0% | 107.2% | 94.0% |

- Бага боловсролын ангийн завсардалтыг 2005 оны түвшнээс 2015 он гэхэд доор дурдсанаар бууруулна. Үүнд.
  - 1 дүгээр ангийн завсардалтыг 4.57 хувиар бууруулж 0.43 хувьд хүргэнэ.
  - 2 дугаар ангийн завсардалтыг 1.54 хувиар бууруулж 0.76 хувьд хүргэнэ.
  - 3 дугаар ангийн завсардалтыг 1.93 хувиар бууруулж 0.87 хувьд хүргэнэ.
  - 4 дүгээр ангийн завсардалтыг 0.62 хувиар бууруулж 0.08 хувьд хүргэнэ.
  - 5 дугаар ангийн завсардалтыг 0.08 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага ангиудад завсардалтыг бууруулах хувь: I анги | 0.43% | 11 | -20.0% | 5.00% | 4.00% | 2.05% | 1.31% | 0.43% |
| II анги | 0.76% | 11 | -9.6% | 2.30% | 2.08% | 1.54% | 1.26% | 0.76% |
| III анги | 0.87% | 11 | -10.1% | 2.80% | 2.52% | 1.83% | 1.48% | 0.87% |
| IY анги | 0.08% | 11 | -17.9% | 0.70% | 0.57% | 0.32% | 0.21% | 0.08% |
| Y анги | 0.08% | 9 | -18.2% | | | 0.33% | 0.22% | 0.08% |

Чанар, нийц:

- Нэг багшид ногдох хотын хүүхдийг 33.5-27.4-т, хөдөөгийн хүүхдийг 30.9-24.7-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сурагч багшийн харьцаа | | | | | | | | |
| Хотод | 27.4 | 11 | -1.8% | 33.5 | 32.9 | 31.1 | 30.0 | 27.4 |
| Хөдөөд | 24.7 | 11 | -2.0% | 30.9 | 30.3 | 28.5 | 27.3 | 24.7 |

- Бүлэг дүүргэлтийг хотод 34.7-36.0-д, хөдөөд 30.9-30.0-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүлэг дүүргэлт | | | | | | | | |
| Хотод | 36 | 11 | 0.3% | 34.7 | 34.8 | 35.2 | 35.4 | 36.0 |
| Хөдөөд | 30 | 11 | -0.3% | 30.9 | 30.8 | 30.5 | 30.4 | 30.0 |

- Багшийн 7 хоногийн цагийн нормыг 19 цаг, сурагчийн 7 хоногийн хичээлийн дундаж цаг 25 байна.
- Бага боловсролыг 100 хувь мэргэжилтэй багшаар хангана.
- Нийт ажиллагчдад эзлэх багш бус ажиллагчдын хувийн жинг хотод 25.3 хувь, хөдөөд 44.2 хувь болгоно.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Нийт ажиллагчдад багш бус ажиллагчдын эзлэх хувь | | | | | |
| Хотод | 29.7% | 26.7% | 24.7% | 24.1% | 25.3% |
| Хөдөөд | 43.5% | 41.7% | 39.8% | 40.2% | 44.2% |

- Багшийн ашиглалтын хувийн жинг хотод 134.0-100.0 хувьд, хөдөөд 135.8-100 хувьд хүргэнэ.

| | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Багшийн ашиглалтын хувь | | | | | | |
| Хотод | -1.0% | 133.9% | 132.5% | 131.2% | 127.0% | 100.0% |
| Хөдөөд | -1.0% | 135.8% | 140.0% | 140.0% | 136.0% | 100.0% |

Дунд, ахлах ангийн талаар

Хамран сургалт:

- Дунд ангийн эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 89.9 хувьд, эмэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 96.9 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Дунд ангийн хамран сургалтын бохир жин эрэгтэй | 90.1% | 86.0% | 95.8% | 93.6% | 89.9% |
| Эмэгтэй | 96.7% | 92.1% | 103.3% | 100.8% | 96.9% |

- Дунд ангид хамрагдах нийт эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 65.0 хувийг хотод хамруулна.
- Ахлах ангид хамрагдах нийт эрэгтэй, эмэгтэй хүүхдийн 75.0 хувийг хотод хамруулна.

Чанар, нийц:

- Дунд, ахлах ангийн сурагч, багшийн харьцааг хотод 22.5-16.9-д, хөдөөд 20.9-14.8-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сурагч, багшийн харьцаа Хотод | 16.9 | 11 | -2.6% | 22.5 | 21.9 | 20.3 | 19.3 | 16.9 |
| Хөдөөд | 14.8 | 11 | -3.1% | 20.9 | 20.2 | 18.4 | 17.3 | 14.8 |

- Дунд, ахлах ангийн бүлэг дүүргэлтийг хотод 34.5-32.0-д, хөдөөд 31.0-28.0-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүлэг дүүргэлт: Хотод | 32 | 11 | -0.7% | 34.5 | 34.3 | 33.6 | 33.1 | 32.0 |
| Хөдөөд | 28 | 11 | -0.9% | 31.0 | 30.7 | 29.9 | 29.3 | 28.0 |

- Дунд, ахлах ангийн багшийн 7 хоногийн цагийн нормыг 19 цаг, сурагчийн 7 хоногийн хичээлийн дундаж цаг 36 байна.
- Дунд, ахлах ангийн багш нар 100 хувь мэргэжлийн багш байна.
- Дунд, ахлах ангийн нийт ажиллагчдад ээлэх багш бус ажиллагчдын хувийн жинг хотод 21.2, хөдөөд 33.7 хувь болгоно.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Дунд, ахлах ангийн нийт ажиллагчдад багш бус ажиллагчдын ээлэх хувь: хотод | 29.7% | 29.7% | 26.1% | 25.8% | 21.2% |
| хөдөөд | 43.5% | 43.9% | 39.7% | 39.4% | 33.7% |

- Дунд, ахлах ангийн багшийн ашиглалтын хувийн жинг хотод 123.6-122.0 хувьд, хөдөөд 127.6-106.0 хувьд хүргэнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Багшийн ашиглалтын хувь: хотод | 123.6% | 119.0% | 120.5% | 115.5% | 122.0% |
| хөдөөд | 127.6% | 119.0% | 116.0% | 105.0% | 106.0% |

Албан бус боловсролын талаар

Хамран сургалт:

- Бичиг үсэг тайлагдалтын түвшинг 2008 он гэхэд 97.7-99.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 (Суурь он) | 2005 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бичиг үсэг тайлагдалтын түвшин | 99.0% | 4 | 0.3% | 97.7% | 98.1% | 99.0% | 99.0% | 99.0% |

- Албан бус боловсрол, гэгээрэл хөгжлийн төвүүдэд хамрагдах бичиг үсэг үл мэдэх эмэгтэйчүүдийн хувийг 75.2 хувиар нэмэгдүүлж 99.0 хувьд, бичиг үсэг үл мэдэх эрэгтэйчүүдийн хувийг 59.5 хувиар нэмэгдүүлж 99.0 хувьд тус тус хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 (Суурь он) | 2005 | 2008 | 2010 | 2015 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| АББ, гэгээрэл хөгжлийн төвүүдэд хамрагдах бичиг үсэг үл мэдэх насанд хүрэгчид: | | | | | | | | |
| эмэгтэй | 99% | 11 | 13.4% | 24.7% | 28.0% | 40.9% | 52.7% | 99.0% |
| эрэгтэй | 99% | 11 | 8.7% | 39.5% | 42.9% | 55.2% | 65.2% | 99.0% |

- Ерөнхий боловсролын сургуулиас завсардсан сурагчдын 40 хувийг албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно.

Чанар, нийц:

- Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв, сум, дүүргийн гэгээрэл, хөгжил, албан бус боловсролын төвийн санхүүжилтийг жил тутам 8 хувиар өсгөнө.
- Албан бус боловсролын багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зардлыг мэргэжил дээшлүүлэх нэгдсэн зардалд тусган жил бүр санхүүжүүлнэ.
- Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтийг бий болгоно.

Менежмент:

- Албан бус боловсролын мэдээлэл, хяналт-шинжилгээний үндэсний систем бий болсон байна.

Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын талаар

Хамран сургалт:

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролд хамрагдах нийт суралцагчдыг 56.1 хувиар нэмэгдүүлнэ.

| | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| МСТБ-ын суралцагчдын тооны өсөлт | 100.0% | 98.1% | 95.3% | 108.5% | 156.1% |

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын хувийн сургуулиудад суралцагчдын хувийг 13.7 хувиар нэмэгдүүлж 15.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| МСТБ-ын хувийн сургуулиудад суралцагчдын эзлэх хувь | 15.0% | 11 | 27.9% | 1.0% | 1.3% | 2.7% | 4.4% | 15.0% |

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын дотуур байрны суралцагчдын хувийг 10.0 хувиар нэмэгдүүлж 25.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| МСТБ-ын дотуур байрны суралцагчдын хувь | 25.0% | 11 | 5.2% | 14.3% | 15.0% | 17.5% | 19.4% | 25.0% |

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролд суралцах нийт эрэгтэй хүүхдийн 94.0-95.0 хувийг, эмэгтэй хүүхдийн 95.0-98.0 хувийг хотод хамруулна.
- Суурь боловсрол эзэмшин төгсөгчдөөс МСҮТ-д элсэгчдийг 9.2 хувиар бууруулж 5.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Суурь боловсрол эзэмшин төгсөгчдөөс МСТБ-д элсэгчид | 5.0% | 10 | 9.9% | 14.2% | 12.79% | 9.35% | 7.59% | 5.00% |

- Бүрэн дунд боловсролын сургуулийг төгсөгчдөөс МСҮТ-д элсэгчдийг 18.0 хувиар нэмэгдүүлж 20.0-иос доошгүй хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс МСТБ-д элсэгчид | 20.0% | 10 | 25.9% | 2.0% | 2.52% | 5.02% | 7.96% | 20.0% |

- Насанд хүрэгчдээс МСҮТ-д элсэгчдийн жилийн дундаж өсөлтийг 15.0 хувь болгож 2015 он гэхэд жилд 8000-аас илүү насанд хүрэгчид МСҮТ-д элсдэг болсон байна.

| | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|
| Насанд хүрэгчдээс МСТБ-д элсэгчид | 15% | 1777 | 2044 | 3110 | 4114 | 8275 |

Чанар, нийц:

- Мэргэжлийн анхан, дунд боловсрол олгох сургуулийн 3800 суудал бүхий хичээлийн байрыг шинээр барина.

| | Зорилт | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|
| Шинээр барих мэргэжлийн анхан, дунд боловсрол олгох сургуулийн хичээлийн байрны суудлын тоо | 3800 | 600 | 1200 | 800 | 1200 |

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын лабораторийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний зардлыг жил бүр 10.0 хувиар өсгөнө.
- МСҮТ-д үзэх мэргэжлийн хичээлийг сурах бичиг, сургалтын гарын авлагатай болгоно.
- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын эмзэг бүлгийн суралцагчдад сурах бичиг, сургалтын гарын авлагыг номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй эзэмшүүлнэ.
- МСҮТ-ийг 100 хувь мэргэжлийн багшаар хангана.
- МСҮТ-ийн сурагч, багшийн харьцааг хотод 19.1-15.0-д, хөдөөд 17.7-15.0-д хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сурагч багшийн харьцаа | | | | | | | | |
| Хотод | 15 | 11 | -2.2% | 19.1 | 18.7 | 17.5 | 16.7 | 15.0 |
| Хөдөөд | 15 | 11 | -1.5% | 17.7 | 17.4 | 16.7 | 16.2 | 15.0 |

- МСҮТ-ийн нийт ажиллагчдад эзлэх багш бус ажиллагчдын хувийн жинг хотод 30.0 хувь, хөдөөд 35.0 хувь болгоно.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Багш бус ажиллагчдын эзлэх хувь | | | | | | | | |
| Хотод | 30.0% | 6 | -6.0% | 43.5% | 40.9% | 34.0% | 30.0% | 30.0% |
| Хөдөөд | 35.0% | 11 | -2.0% | 43.8% | 42.9% | 40.4% | 38.8% | 35.0% |

- Мэргэжлийн сургалт, техникийн боловсролын багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.
- Жил бүр 20 багшийг гадаадад нарийн мэргэжлээр мэргэшүүлэх мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.

Менежмент:

- МСТБ-ын нийгмийн түншлэлийн удирдлага, менежмент бий болсон байна.
- МСТБ-ын гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого, эрх зүйн таатай орчин бий болсон байна.

Дээд боловсролын талаар

Хамран сургалт:

- Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н мэргэжлийн чиглэлээр суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувийн жинг 29.1-45.0 хувь болгож өсгөх бодлого баримтална. Үүнд:
  - Инженер, технологийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 13.0-25.0 хувьд,
  - ХАА-н мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 3.1-6.0 хувьд,
  - Байгалийн шинжлэлийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 2.9-4.0 хувьд,
  - Багшийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 9.8-10.0 хувьд тус тус хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Инженер, технологи | 25.0% | 11 | 5.9% | 13.3% | 14.1% | 16.7% | 18.8% | 25.0% |
| Хөдөө аж ахуй | 6.0% | 11 | 6.1% | 3.1% | 3.3% | 4.0% | 4.5% | 6.0% |
| Байгалийн шинжлэл | 4.0% | 11 | 3.0% | 2.9% | 3.0% | 3.3% | 3.5% | 4.0% |
| Багш | 10.0% | 11 | 0.2% | 9.8% | 9.8% | 9.9% | 9.9% | 10.0% |

- Бусад мэргэжлийн чиглэлээр суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувийн жинг 38.9-34.0 хувьд хүргэнэ. Үүнд:
  - Нийгэм, хүмүүнлэгийн ухааны мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 18.5-10.0 хувьд,
  - Хуулийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 5.8-4.0 хувьд,
  - Анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 7.7-7.0 хувьд тус тус хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бусад мэргэжлийн чиглэлээр суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувь | 34.0% | 11 | -1.2% | 38.9% | 38.4% | 37.0% | 36.1% | 34.0% |
| Үүнд: Нийгэм хүмүүнлэгийн ухаан | 10.0% | 11 | -5.4% | 18.5% | 17.5% | 14.8% | 13.2% | 10.0% |
| Хууль | 4.0% | 11 | -3.3% | 5.8% | 5.6% | 5.1% | 4.7% | 4.0% |
| Анагаах ухаан | 7.0% | 11 | -0.9% | 7.7% | 7.7% | 7.5% | 7.3% | 7.0% |

- Хувийн их, дээд сургуулийн оюутнуудын нийт суралцагчдад эзлэх хувийг 6.7 хувиар бууруулж 25.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хувийн их, дээд сургуулийн оюутнуудын нийт суралцагчдад эзлэх хувь | 25.0% | 11 | -2.1% | 31.7% | 31.1% | 29.1% | 27.9% | 25.0% |

- Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс тухайн жилд их, дээд сургуульд элсэгчдийг 11.0 хувиар бууруулж 70.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЕБС төгсөгчдөөс тухайн жилдээ их, дээд сургуульд элсэгчдийн хувь | 70% | 4 | -3.6% | 81.0% | 78.1% | 70.0% | 70.0% | 70.0% |

- Их, дээд сургуульд шинээр элсэгч бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн хувийг 31.0 хувиар бууруулж 50.0 хувьд, бусад элсэгчдийн хувийг 25.2 хувиар нэмэгдүүлж 50.0 хувьд хүргэнэ.

| | Зорилт | Товлосон жил | Жилийн өсөлтийн хувь | 2004 2005 (Суурь он) | 2005 2006 | 2008 2009 | 2010 2011 | 2015 2016 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Их, дээд сургуульд шинээр элсэгчдэд: | - | | | | | | | |
| ЕБС төгсөгчдийн эзлэх хувь | | | | 75.2% | 74.0% | 70.0% | 70.0% | 50.0% |
| Бусад элсэгчдийн эзлэх хувь | 30% | 4 | 4.9% | 24.8% | 26.0% | 30.0% | 30.0% | 50.0% |

Чанар, нийц:

- Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА, анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр суралцах 4 оюутан тутмын 3-т нь, бусад мэргэжлийн чиглэлээр суралцах 4 оюутны 1-д нь төрийн сургалтын сангаас сургалтын төлбөрийн зээл олгох бодлогыг баримтална.
- Дээд боловсролын багш нарын дотоодод мэргэжил дээшлүүлэх зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлнэ. Жил бүр 100 багшийн мэргэжлийг гадаадад дээшлүүлнэ.
- Дээд боловсролын хөрөнгө оруулалтын зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлнэ.

Менежмент:

- Дээд боловсролыг үндэсний эдийн засгийн бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх бодлого, менежмент бий болсон байна.

# IY БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
## (2006 - 2010 он)

4.1. Бага насны хүүхдийн боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө (2006-2010 он)

| Хэрэгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн бүрэлдэхүүн | Гарцын үр дүн ба шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| | Хүртээмж | |
| | Зорилго 1. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 99.0 хувьд хүргэх | |
| 1.1. Цэцэрлэгийн хамран сургалтын хүрээг өргөжүүлнэ | 1.1.1. Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон болон зарим аймгуудад цэцэрлэгийг шинээр барих, өргөтгөх<br>1.1.2. Цэцэрлэгийн ээлжийн, улирлын, түр сургалтын үйлчилгээг өргөжүүлэх<br>1.1.3. Хувийн цэцэрлэг байгуулахыг төрөөс хөхиүлэн дэмжих, магадлан итгэмжлэгдсэн хувийн цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлэх | • Хүүхдийн цэцэрлэгийн ор/суудал 3650-аар нэмэгдсэн байна.<br>• Хотын хүүхдийн 85.0 хувь, хөдөөгийн хүүхдийн 35.0 хувийг цэцэрлэгт хамруулна.<br>• Нийт суралцагчдад хувийн цэцэрлэгийн хүүхдийн эзлэх хувийг 6.5-д хүргэнэ.<br>• Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхэд 11.6-д, бүлэг дүүргэлт 25.0-д байна. |
| 1.2. Хөдөөгийн малчин айл өрхийн хүүхдэд зориулсан цэцэрлэгийн бус сургуулийн өмнөх боловсролын институтчилэгдсэн үйлчилгээг бий болгоно | 1.2.1. Орон нутагт малчдын хүүхдийн хэгжлийг хангах гэр бүл төвтэй явуулын, улирлын, эцэг, эхийн, зайны сургалтын үйлчилгээг бий болгох<br>1.2.2. Хөдөөгийн багийн бага оврын сургуулийн үйл ажиллагааг СӨБ-ын чиг үүргээр өргөжүүлэх<br>1.2.3. Малчдын хүүхдэд зориулсан гэр бүлд тулгуурласан үйлчилгээний стандарт, сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсруулан мөрдөх, багшийг давтан бэлтгэх, сургалтын зардал, багшийн цалингийн асуудлыг шийдвэрлэх | • Хотын хүүхдийн 14.0 хувийг, хөдөөгийн хүүхдийн 64.0 хувийг сургуулийн өмнөх боловсролын цэцэрлэгээс бусад хэлбэрийн сургалтад хамруулна.<br>• Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу айл өрхийн хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг 2005 оны түвшнээс 50 хувиар нэмэгдүүлнэ.<br>• Хөдөөгийн малчдын бага насны хүүхдэд зориулсан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ нь институтчилэгдсэн байна. |
| 1.3. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой нэн ядуу айл өрхийн бага насны хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ | 1.3.1. СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хөдөөгийн болон хотын захын хорооллын нэн ядуу айл өрхийн хүүхдүүдэд зориулсан олон хувилбарт үйлчилгээг бий болгох<br>1.3.2. Хөдөөгийн болон хотын захын хорооллын цэцэрлэгт хамрагдаж буй нэн ядуу айл өрхийн хүүхдүүдийн хоолны зардлыг нийгмийн халамжийн сангаас хариуцах | • Сургуульд бэлтгэх олон хувилбарт сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, хүүхэд, багш, гэр бүлд ашиглагдах гарын авлага, материалууд бий болсон байна.<br>• Цэцэрлэгийн бус сургалтыг зохион байгуулах удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхи бий болсон байна. |
| 1.4. Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг өргөжүүлнэ | 1.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг эрт оношлох, нөхөн сэргээх, асаргаа сувилгаа, боловсролын үйлчилгээнд хамруулах нийгмийн нөхцөлийг бий болгох<br>1.4.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан гэр бүлд түшиглэсэн эрүүл мэнд, асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх үйлчилгээний хэлбэрийг бий болгох<br>1.4.3. Ердийн цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулах тусгайлсан бодлогыг хэрэгжүүлэх<br>1.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах арга зүй, ур чадварыг багш нарт эзэмшүүлэх | • Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээний орчин бий болсон байна.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хамрагдалт 2005 оны түвшнээс 50 хувиар нэмэгдсэн байна.<br>• Ердийн цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах материаллаг, нийгэм, сэтгэл зүйн орчин болон багшлах хүний нөөцийн чадавхи бий болсон байна. |

| ЧАНАР | | |
|---|---|---|
| Зорилго 2. Бага насны хүүхдүүдийн хөгжлийн хэрэгцээг хангахуйц чанартай боловсролын үйлчилгээг бий болгох | | |
| 2.1. Цэцэрлэгийн ундны цэвэр ус, хоол, хүнсний хангамж, үйлчилгээг сайжруулна | 2.1.1. Цэцэрлэгийн хоолны зардлыг бага насны хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээлийн нормд тулгуурлан тогтооно. 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох хоолны жилийн нормыг 61.1 (нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардал 300.0 төгрөг байсныг 484.0 төгрөг болгоно) хувиар өсгөж 116.000 төгрөгөөр тооцож санхүүжүүлнэ.<br>2.1.2. Цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж, сав суулгыг шинэчлэх, эрүүл ахуйн стандартад нийцүүлэх<br>2.1.3. Цэцэрлэгүүдэд ундны цэвэр усны эрүүл мэнд, эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангасан орчин бүрдүүлэх | • 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хүүхдийн физиологийн нормативт нийцсэн хоол хүнсний хангамж бий болно.<br>• Цэцэрлэгийн ундны цэвэр ус, хоол хүнсний аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах, чанарын баталгааны түвшин стандартын шаардлагад нийцсэн байна. |
| 2.2. Цэцэрлэгийн барилгын болон сургалтын материаллаг орчныг сайжруулна | 2.2.1. Цэцэрлэгийн барилгын болон сургалтын орчны стандартыг боловсруулан баталгаажуулж мөрдүүлснээр цэцэрлэгийн материаллаг орчны эрүүл, аюулгүй, хэвийн нөхцөлийг хангах<br>2.2.2. Гадаа бие засах байгууламж, ариун цэврийн өрөөний тусгайлсан стандарт боловсруулан мөрдүүлэх<br>2.2.3. Цэцэрлэгүүдийг засварлах засварын хөтөлбөрийг хэрэгжүүлэх<br>2.2.4. Цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулах | • Цэцэрлэгийн барилгын болон сургалтын орчны стандарт бий болсон байна.<br>• Бүх цэцэрлэгийн бие засах байгууламж стандартын шаардлагад нийцсэн байна.<br>• Цэцэрлэгийн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг 2005 оны түвшнээс 1.7 дахин нэмэгдүүлсэн байна.<br>• Засварлах шаардлагатай нийт цэцэрлэгийн 29.8 хувийг засварласан байна. |
| 2.3. Бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээний цогц стандартыг боловсруулж нэвтрүүлэх | 2.3.1. Бага насны хүүхдийн хөгжлийн цогц стандартыг боловсруулж турших, батлан мөрдүүлэх<br>2.3.2. Шинэ стандартад нийцсэн багшийн гарын авлагыг зохиох, хэвлэх ажлыг төрөөс дэмжих | • Бага насны хүүхдийн хөгжлийн цогц стандарттай болсон байна.<br>• СӨБ-ын хүүхэд, багш нарт зориулсан 4-өөс доошгүй төрлийн багшийн гарын авлага, сургалтын материалтай болсон байна. |
| 2.4. СӨБ-ын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх | 2.4.1. СӨБ-ын багш бэлтгэх хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжүүлэх<br>2.4.2. Цэцэрлэгийн үндсэн багш нарыг 100 хувь мэргэжлийн багшаар хангах<br>2.4.3. Шинэ стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх сургалтын модулиуд боловсруулах, мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах<br>2.4.4. Цэцэрлэгийн туслах багш нарт зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах<br>2.4.5. Цэцэрлэгийн бус хэлбэрийн сургуулийн өмнөх боловсролын сургалт, арга зүйн модулиуд боловсруулах, сургалтыг зохион байгуулах<br>2.4.6. СӨБ-ын мэргэжилтэн, багш нарыг гадаад улс орнуудад мэргэжлийг нь дээшлүүлэх, туршлага судлах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ<br>2.4.7. Хүүхдийн цэцэрлэгийн удирдах ажилтнууд, бусад мэргэжилтнүүдэд зориулсан бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээний менежментийн шинэ ур чадварыг эзэмшүүлэх мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх | • Жил бүр СӨБ-ын багш нарын 50-иас доошгүй хувийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулна.<br>• Цэцэрлэгийн үндсэн багшийг 100 хувь мэргэжлийн багшаар, бүх цэцэрлэгийг 100 хувь туслах багшаар хангана.<br>• Жил бүр 30 багш, мэргэжилтнийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах хөтөлбөрт хамруулна.<br>• СӨБ-ын багш бэлтгэх сургуулиудын сургалтын агуулга, хөтөлбөр шинэчлэгдсэн байна.<br>• Шинэ стандартыг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр бий болсон байна.<br>• Цэцэрлэгийн бус СӨБ-ын болон цэцэрлэгийн туслах багш нарт зориулсан сургалтын модулиуд бий болсон байна.<br>• СӨБ-ын боловсролын менежментийн сургалтын модулиуд бий болсон байна. |

| МЕНЕЖМЕНТ | | |
|---|---|---|
| Зорилго 3. Бага насны хүүхдийн үйлчилгээний бодлого, эрх зүй, менежментийг боловсронгуй болгох | | |
| 3.1. Хувийн хэвшил, бусад сонирхлын бүлгүүдээс бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг эрхлэхийг бодлогоор дэмжин урамшуулах | 3.1.1. Хувийн хэвшил, бусад сонирхлын бүлгүүдээс бага насны хүүхдийн үйлчилгээг эрхлэх сонирхлыг дэмжих эрх зүйн таатай орчин бий болгох<br>3.1.2. Бага насны хүүхдийн үйлчилгээний стандартыг боловсруулж мөрдөх<br>3.1.3. Хүүхдийн халамж, асран сувилахуйн мэргэжлийн чиглэлийг бий болгох, мэргэжилтэн бэлтгэх<br>3.1.4. Бага насны хүүхдийн үйлчилгээний стандарт, магадлан итгэмжлэлийг хөгжүүлэх<br>3.1.5 Бага насны хүүхдийн үйлчилгээний аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах, чанарын баталгааны хяналтыг бий болгох | • Бага насны хүүхдэд зориулсан хүүхэд асрах төв, хүүхдийг ажил дээр нь болон гэрт нь харах, асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх гэх мэт үйлчилгээний төрөл, хэлбэр, тоо олширсон байна.<br>• Бага насны хүүхдийн үйлчилгээний стандарт, хяналтын механизм бий болсон байна. |
| 3.2. Бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээний удирдлага, менежментийн нэгдмэл байдлыг бий болгох | 3.2.1. Бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээг эрхэлж буй салбарын яамд, байгууллагуудын нэгдмэл хамтын үйл ажиллагааны менежментийг бий болгох<br>3.2.2. Бага насны хүүхдийн үйлчилгээний талаар салбар дундын мэдээллийн бааз, нэгдсэн сүлжээ байгуулах | • Бага насны хүүхдийн салбар дундын удирдлага, мэдээлэл, үйл ажиллагааны нэгдмэл байдал бий болсон байна. |

| | |
|---|---|
| Дэм үр дүн ба шалгуур үзүүлэлт | • Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын бохир жинг 99.0 хувьд хүргэнэ. |
| | • 1 дүгээр ангид элсэгчдээс сургуульд бэлтгэх сургалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь 2015 онд 99 хувьд хүрнэ. |
| | • Нүүдлийн амьдралын хэв маягт нийцсэн хөдөөгийн малчдын бага насны хүүхдийн үйлчилгээ бий болно. |
| | • Бага насны хүүхдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээний төрөл, хэлбэр, сонгох боломжийг бий болгосноор үйлчилгээний тэгш байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. |
| | • Бага насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийн ялгаатай тэгш бус байдлыг бууруулах боломж бүрдсэнээр бага боловсролын хүртээмж, чанар, дотоод үр ашиг дээшилнэ. |
| | • Цэцэрлэгийн материаллаг болон сургалтын үйл ажиллагааны орчин сайжирснаар хүүхдүүд аюулгүй, эрүүл, эсэн мэнд өсөж хөгжих, чанартай үйлчилгээг хүртэх боломж өргөжинө. |
| | • Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа, нийгмийн халамж, боловсролын үйлчилгээний цогц менежмент бий болно. |

4.2. Бага, дунд боловсролын дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө
(2005 - 2010 он)

| Хэрэгжүүлэх хөтөлбөр | Хөтөлбөрийн бүрэлдэхүүн | Гаралтын үр дүн ба шалгуур үзүүлэлт |
|---|---|---|
| | Хүртээмж | |
| Зорилго 1. Суралцагчдад чанартай боловсрол эзэмших тэгш боломж олгогдохгүй байгаа ялгаа багасгах, суралцах эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх | | |
| 1.1. Суурь боловсролын хамран сургалтын хүрээг нэмэгдүүлэх | 1.1.1. ЕБС-ийг 11 ба 12 жилийн бүтцэд шилжүүлэхэд 6 ба 7 настай хүүхдүүдийг сургуульд бүрэн хамруулах<br>1.1.2. ЕБС, дотуур байрны байршил, хүчин чадлын судалгаа гаргах<br>1.1.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийн өөрчлөлттэй холбоотойгоор ЕБС-ийн бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой болгох<br>1.1.4. Сургуулиудын хичээлийн болон дотуур байрны барилгыг шинээр барих, өргөтгөх<br>1.1.5. Хувийн бага, дунд сургуулиуд хөгжих эрх зүйн зохицуулалтыг сайжруулах | • 2006 оноос эхлэн долоон настай хүүхдийн 99.9 хувийг сургуульд элсүүлсэн байна<br>• 2008 оноос эхлэн зургаан настай хүүхдийн 99.9 хувийг сургуульд элсүүлдэг болсон байна<br>• 2008 он гэхэд сургуулийн шинэ зураглал боловсрогдсон байх ба 2010 он гэхэд мөрдөгдөнө<br>• Сургуулийн суудлын тоог 2010 он гэхэд 35.9 мянган шинэ суудлаар, дотуур байрны орны тоог 2.7 мянган ороор нэмэгдүүлсэн байна.<br>• Хувийн сургуулиудын оролцоог нэмэгдүүлж, нийт суралцагчдын 10.0 хүртэлх хувийг хувийн сургуулиудад хамруулна. |
| 1.2 Бага ангийн сурагчид, малчдын хүүхэд боловсролын чанартай үйлчилгээ авах тэгш боломж бүрдүүлэх | 1.2.1. Сургуульд бэлтгэгдсэн байдлын ялгаа багасгах богино хугацааны хөтөлбөр боловсруулж, сургалтын явцад хэрэгжүүлэх<br>1.2.2. Суралцах явцад үүсч буй бэрхшээлийг оношлон сурах бэрхшээл үүссэн хүүхдэд тухайн бэрхшээлээс гарахад нь туслах<br>1.2.3. Нийгмийн янз бүрийн давхраанаас сургуулийн шинэ орчинд хөл тавьж буй 1,.2 дугаар ангийн сурагчидтай ажиллах, сурах бэрхшээл үүсэх, анги улирахаас сэргийлэх арга зүйг багшид эзэмшүүлэх<br>1.2.4. Сургалтын чанарыг бууруулахгүйгээр багийн сургуулиудыг дэмжих<br>1.2.5. Хүүхдийн суралцах идэвхи, сонирхлыг дэмжсэн сургалтын арга, үнэлгээг нэвтрүүлж, сурагчдын дүнгийн нууцлалыг хэрэгжүүлэх<br>1.2.6. Дотуур байрны үйлчилгээг сайжруулах<br>1.2.7. Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн сурч боловсроход эцэг эхийн хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх<br>1.2.8. Цэцэрлэг–бага сургуулийн цогцолбор хичээлийн байрны барилга барих | • Боловсрол эзэмших тэгш боломжийг хангах үйлчилгээний төрлүүд бий болно<br>• ЕБС-ийн улирагсдыг 2004 оны түвшнээс 34.0 хувиар бууруулж 66.0 хувьд хүргэнэ<br>• Бага боловсролын ангийн завсардалтыг 2005 оны түвшнээс 2010 он гэхэд дор дурдсанаар бууруулна. Үүнд:<br>➢ I ангийнхыг 3.69% бууруулж 1.31 %-д,<br>➢ II ангийнхыг 1.04% бууруулж 1.26 %-д,<br>➢ III ангийнхыг 1.32% бууруулж 1.48 %-д<br>➢ IY ангийнхыг 0.49% бууруулж 0.21 %-д<br>➢ Y ангийнхыг 0.22%-д тус тус хүргэнэ<br>• Дүнгийн нууцлалыг хадгалах эрх зүйн орчин бүрдүүлэх арга хэмжээ авна.<br>• Үнэлгээний журам өөрчлөгдсөн байна.<br>• Дотуур байранд хамрагдах малчдын хүүхдийн хамран сургалтыг 18.2 хувиар нэмэгдүүлж 52.7 хувьд хүргэнэ<br>• Бага сургуулийг эцэг эх, гэр бүлд ойртуулна<br>• Дотуур байранд амьдарч буй хүүхдийн хоолны нэгжийн зардлыг 2004 онтой харьцуулахад жил бүр дунджаар 8 хувиар өсгөх |

| | | |
|---|---|---|
| 1.3 Анги улирал, сургууль завсардалтыг бууруулах, эмзэг бүлгийн суралцагчдыг завсардалтгүй суралцахад нь дэмжлэг үзүүлэх | 1.3.1. Анги улирал, сургууль завсардалтын шалтгааныг судалж тэдгээрийг арилгах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх<br>1.3.2. Сургууль завсардагчдыг завсардсан эхний 2 жилд нь багтаан сургуульд нь буцааж суралцуулах, 3 дахь жилээс нь боловсрол нөхөн олгох сургалтад хамруулах<br>1.3.3. Сургуульд нь буцаах тусгайлсан хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх<br>1.3.4. Боловсрол нөхөн олгох албан ба АББ-ын хамтарсан үйл ажиллагааг бий болгож үүрэг, хариуцлагыг тодорхой болгох<br>1.3.5. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдийг хичээлийн хэрэглэлээр хангах<br>1.3.6. Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн хүүхдэд сурах бичгийг эрхийн бичгээр үнэгүй олгох | • Ерөнхий боловсролын сургуулиас завсардагчдыг 2004 оны түвшнээс 67.8 хувиар бууруулж 32.2 хувьд хүргэнэ.<br>• ЕБС-иас завсардсан сурагчдын 20.0 хувийг эхний жилд, дараагийн жилд нь 40.0 хувийг нь сургуульд буцаан оруулна.<br>• Багаас дунд боловсролд дэвшин суралцагчид 2008 онд 98.8 %, 2010 онд 99.1% болох ба суурьас бүрэн дунд боловсролд дэвшин суралцагчид 2008 онд 88.9%, 2010 онд 90.6% болно. |
| 1.4 Ерөнхий боловсролын сургуулийн 1, 2 дугаар ангийн сурагчдад үдийн цай өгөх ажлыг хэрэгжүүлэх | 1.4.1. Сурагчдад үдийн цайгаар үйлчлэхэд шаардагдах бүх стандартыг боловсруулж, эрх зүйн орчинг бүрдүүлэх<br>1.4.2. 1, 2 дугаар ангийн бүх сурагчдад үдийн цайгаар үйлчлэх зардлыг төрөөс хариуцах эрх зүйн зохицуулалтыг бий болгох<br>1.4.3. Үдийн цайгаар үйлчлэх арга хэлбэр бий болгох<br>1.4.4. Сургууль дээр үдийн цайгаар үйлчлэх менежментийг бий болгох | • Сурагчдыг үдийн цайгаар үйлчлэхэд шаардагдах стандарт мөрдөгдөнө.<br>• Сурагчдыг үдийн цайгаар үйлчлэх санхүүжилт шийдвэрлэгдэж нийлүүлэлтийн тогтолцоо бүрдэнэ<br>• 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн бага ангийн 1, 2 дугаар ангийн хүүхдүүдэд үдийн цай, хоол өгнө. |
| 1.5 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг өргөжүүлж боловсролд бүрэн хамруулах | 1.5.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд хамруулан сургах<br>1.5.2. Ердийн сургуулийн багш, суралцагчдад мэргэжлийн байгууллагууд, ажилтнуудаас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бий болгох<br>1.5.3. Тусгай сургуулиудаас ердийн сургуулийн багш, суралцагчид, эцэг эхчүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлдэг болгох<br>1.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролын хэрэгцээг судалж, боловсролын тусгай хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх<br>1.5.5. Багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах мэдлэг туршлага эзэмшүүлэх<br>1.5.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүнээр сургуулиудыг хангах | • Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн оношилгоо, судалгаанд суурилсан үйлчилгээний төрөл, хэлбэр өргөжиж, хүрээ нь тэлсэн байна.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролд хамрагдах хот, хөдөөгийн ялгаа багасаж, тэдний суралцах боломж нэмэгдэнэ.<br>• Сургуулийн гадна байгаа хүүхдүүдэд боловсрол эзэмшүүлэх институтчилэгдсэн үйл ажиллагаа бий болсон байна. |

| ЧАНАР | | |
|---|---|---|
| Зорилго 2. Бага, дунд боловсролын чанартай үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх | | |
| 2.1. Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэх, ЕБС-ийг 12 жилийн бүтцэд шилжүүлэх бэлтгэлийг хангах | 2.1.1. ЕБС-ийг 12 жилийн бүтцэд шилжүүлэхтэй холбогдуулан сургуулийн хичээлийн ба дотуур байрны суудлын тоо, багшийн хангамж, төсөвт зардал зэрэг асуудлаар судалгаа хийж шилжүүлэх бэлтгэл ажлыг төлөвлөгөө, графикийн дагуу хэрэгжүүлэх<br>2.1.2. Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг 12 жилийн бүтцэд нийцүүлэн өөрчилж, боловсролын удирдах ажилтан, багш нарт зориулсан сургалтууд зохион байгуулах<br>2.1.3. 6 ба 7 настай хүүхдийг сургах агуулга, арга зүй, сургалтын орчныг тодорхойлох<br>2.1.4. Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээг туршин боловсруулах | • Бэлтгэл ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.<br>• Төсөв, зардал, санхүүжилтийн асуудлууд шийдэгдсэн байна.<br>• Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөөг 12 жилийн бүтцэд нийцүүлэн мөрдөнө<br>• 6 ба 7 настай хүүхдийг сургах агуулга, арга зүйг боловсруулж, тэднийг сургах орчин бүрдсэн байна.<br>• Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээг боловсруулж хэрэгжүүлнэ |
| 2.2. Багшийн хангалт, ашиглалт ба багшийн ажлын ачааллыг оновчтой болгох | 2.2.1. ЕБС-ийг 12 жилийн бүтцэд шилжүүлэхтэй холбоотойгоор үүсэх багшийн хангамж, ажлын ачааллын өөрчлөлтийг зохицуулах<br>2.2.2. Хөдөөгийн багшийн хангамжийг сайжруулах эрх зүйн болон эдийн засгийн урамшууллын арга хэлбэрийг боловсруулж мөрдөх<br>2.2.3. Хөдөөгийн сургуульд мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи нэвтрүүлэх<br>2.2.4. Багшаар хангах бодлого, стратегийг шинэчлэх, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үйлчилгээний агуулга, арга зүй, үнэлгээг оновчтой болгох, хүртэц, чанарыг сайжруулах | • Бүх сургууль мэргэжлийн багшаар бүрэн хангагдана<br>• Залуу, чадварлаг багш нарын хөдөө ажиллах сонирхлыг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ахуй амьдралыг нь баталгаажуулах уян хатан арга хэлбэр хэрэглэгдэнэ.<br>• Бага боловсролд багшийн ашиглалтын хувийн жинг хотод 134.0-127.0 хувьд, хөдөөд 135.8-135 хувьд, дунд, ахлах ангийн багшийн ашиглалтын хувийн жинг хотод 123.6-115.5 хувьд, хөдөөд 127.6-105.0 хувьд тус тус хүргэнэ. |
| 2.3. Багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоог шинэчлэн сайжруулах | 2.3.1. Сургуулийн бүтэц, хэв шинжийн онцлог, шинэ стандартын шаардлагад нийцүүлэн "Багш" мэргэжилтний загварыг шинэчлэх<br>2.3.2. "Багш" мэргэжилтний загварт нийцсэн "багш боловсрол"-ын стандартыг шинэчлэн боловсруулж мөрдөх<br>2.3.3. Зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу хөрвөх боломж олгосон модулийн тогтолцоо бүхий кирикюлимийг боловсруулж хэрэгжүүлэх<br>2.3.4. Багш боловсролын шинэ стандарт, кирикюлимийг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчны стандартууд боловсруулж мөрдөх<br>2.3.5. Стандартад нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг нийлүүлэх<br>2.3.6. Багш боловсролын шинэ стандарт, кирикюлимийг хэрэгжүүлэх хүний нөөцийг чадавхижуулах | • 2008 он гэхэд багш боловсролын стандарт, кирикюлимийг боловсруулан баталгаажуулсан байна.<br>• 2010 он гэхэд баталгаажсан стандарт, кирикюлимээр явагдах сургалт жигдэрсэн байна.<br>• Боловсрол дахь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу багш мэргэжлээрээ хөрвөх, өөр салбараас чадварлаг боловсон хүчин татагдан ажиллах боломжтой уян хатан, нээлттэй тогтолцоо бүрдэнэ.<br>• Чанартай багш, удирдах ажилтан бэлтгэгдэх таатай орчин бүрдэнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| 2.4 | Сургууль тэвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоог төлөвшүүлэх | 2.4.1. Багш нар ажил дээрээ тасралтгүй суралцахад тохиромжтой орчны стандартыг боловсруулж гаргах<br>2.4.2. Зайны сургалтын үндсэний сүлжээний хүртээмж, ашиглалт, найдвартай ажиллагааг нэмэгдүүлэх<br>2.4.3. Багш нар сургууль дээрээ мэргэжил дээшлүүлэхэд орон нутгийн болон үндэсний түвшний байгууллагуудаас мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чадавхийг нэмэгдүүлэх<br>2.4.4. Цөцөлбор, бүсийн тэв сургуулиудыг багш нарын мэргэжил дээшлүүлэх түшиц нэгж болохуйцаар хөгжүүлэх<br>2.4.5. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх санхүүгийн бодлон үйл ажиллагааны менежментийг боловсронгуй болгох, мэргэжил дээшлүүлэх зардлыг сургуулийн төсөвт тусгадаг болох | • Багш ажлын байрандаа бие даан мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх боломж бүрдэнэ.<br>• Нийт сургуулийн 60%-д багшийн ажлын орчин стандартын түвшинд хүрч сайжирсан байна.<br>• Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зайны сургалтын арга хэлбэрүүд, МХТ-ийг ашигладаг болсон байна.<br>• Багш нарын мэргэжил, арга зүйн ур чадвараа хөгжүүлж байх сонирхол, хэрэгцээ дэмжсэн арга хэлбэрүүд бий болсон байна. |
| 2.5 | Шинэ стандарт, кирриюлимийг хэрэгжүүлэх багш нарын мэргэжил, арга зүйн ур чадварыг дээшлүүлэх | 2.5.1. Шинэ стандарт, кирриюлимийг хэрэгжүүлэх багш нарын мэргэжил, арга зүйн чадварыг дээшлүүлэх сургалтын модулийн тогтолцоог бий болгож гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, түгээх<br>2.5.2. Мэдээллийн технологи ашиглан хичээл заах талаар багш нарт зориулсан сургалт зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага бэлтгэнэ<br>2.5.3. Тодорхой бодлогоор гадаадын улс орнуудад мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, дэвшилтэт туршлага, арга зүйг судлах, нэвтрүүлэх<br>2.5.4. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд тодорхой чиглэлээр бэлтгэгдсэн сургагч багш нарын мэдлэг чадварыг аймаг, нийслэл, сум, дүүргийн бусад сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд үр өгөөжтэй ашиглах<br>2.5.5. Сургууль дээр сургалтад боловсролын ТВ, интернет зэрэг мэдээлэл харилцааны шинэ технологи ашиглах боломжийг өргөжүүлэх | • Шинэ стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх цуврал сургалтад багш бүр хамрагдсан байна.<br>• Багш нар компьютер болон интернет ашиглан сургалт явуулж, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх арга ухаанд суралцсан байна.<br>• Багш, удирдах ажилтны дотооддоо мэргэжил дээшлүүлэх нийт зардал 2004 онтой харьцуулахад 2008 онд 7 дахин, 2010 онд 7.3 дахин өссөн байна.<br>• Жил бүр ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.<br>• Жил бүр 200 багш, удирдах ажилтныг гадаадад мэргэжил дээшлүүлнэ. |
| 2.6 | Багш, арга зүйчид, удирдах ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой болгож, тэдгээрийн цалин, нэмэгдэл хөлс, тэтгэлэг, урамшууллын тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх | 2.6.1. Ажлын гүйцэтгэлийн чанарыг ил тод, шударга үнэлэх үндсэн дээр нэмэгдэл хөлс, урамшууллыг олгох эрх зүйн зохицуулалт хийх<br>2.6.2. Амьдрах, ажиллах орчны ялгаатай байдлыг тооцсон нэмэгдэл урамшил олгох<br>2.6.3. Багш, ажилтнуудынхаа эрүүл мэнд, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх талаар орон нутаг, сургууль, хамт олны идэвхи санаачилгыг дэмжих<br>2.6.4. Багшийн ёс зүйг хамгаалсан эрх зүйн орчин бүрдүүлэх<br>2.6.5. Мэргэжлийн ур чадварын өсөлтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгох<br>2.6.6. Багшид зориулсан ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг сайжруулахад төрөөс дэмжлэг үзүүлэх | • Багшийн үндсэн цалинг 2004 онтой харьцуулахад жил бүр дунджаар 14.2, багш бус ажилтныхыг 10.6 хувиар тус тус өсгөж, 2010 он гэхэд багш 180500 төгрөг, багш бус ажилтан 150800 төгрөгийн үндсэн цалин авна.<br>• Бага, дунд боловсролын нийт зардал дахь багш ба багш бус ажилтны цалингийн эзлэх хувь 2010 онд 2004 онтой харьцуулахад 2.8% өссөн байна.<br>• Орон нутаг, байгууллагын хамт олноо хөгжүүлэх, амьдарч ажиллах орчноо сайжруулах, нийгмийн асуудлаа шийдвэрлэх сонирхол, хүчин чармайлт нэмэгдэнэ.<br>• Багшийн ур чадварын бодит өсөлт, сургалтад үзүүлэх үр өгөөж, хөгжилд оруулж буй хувь нэмэр, гүйцэтгэх үүрэг хариуцлагад нийцсэн урамшууллын тогтолцоотой болно.<br>• 2008 он гэхэд эрх зүй, эдийн засгийн арга механизмууд баталгаажин мөрдөгдөж эхлэх ба 2010 он гэхэд үйл ажиллагаа хэвшинэ. |

| | | |
|---|---|---|
| 2.7. Сурах бичгийн чанар, хангамж сайжрах шудрага өрсөлдөөний орчин бий болгож, хэрэглэгчид сурах бичиг, номоо сонгож хэрэглэх боломжийг бүрдүүлэх | 2.7.1. Сурах бичгийн чанар болон түгээлтийн төлөө шудрага өрсөлдөөнийг дэмжсэн эрх зүйн орчинг боловсронгуй болгох<br>2.7.2. Сурах бичгийн стандарт, сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журмыг шинэчлэн мөрдөх<br>2.7.3. Шинэ стандартын дагуу ЕБС-ийн сурах бичгүүдийг шинэчлэх<br>2.7.4. Сурах бичиг худалдаалах тогтолцоонд үе шаттайгаар шилжих<br>2.7.5. Сурах бичгийг дотооддоо хэвлэх боломж олгохуйц төлөвлөлттэй болох<br>2.7.6. Сурах бичиг бүтээх хүний болон технологийн чадавхийг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах<br>2.7.7. Дуут, цахим хэлбэрийн сурах бичиг бий болгож, тэдгээрийг ашиглах арга технологийг нэвтрүүлэх<br>2.7.8. Сурах бичиг худалдан авах чадварын судалгаа хийж, ядуу, эмзэг бүлгийн хүүхдийг сурах бичгээр хангахад төр, олон нийтээс дэмжлэг үзүүлэх<br>2.7.9. Англи хэлний сурах бичгийг шинэчилж, англи хэлээр унших хүүхдийн ном, хэвлэлийг нэмэгдүүлэх<br>2.7.10. Сургуулиудын номын сан бага ангийн сурагчид хичээлээс гадуур унших номын хөмрөгөөр баяжуулах | ▪ Ерөнхий боловсролын сургуулийн сурагч бүр хичээл бүрийн нэг сурах бичиг, багш бүр заадаг хичээлийнхээ багшийн гарын авлагатай байна.<br>▪ Эрэлт хэрэгцээнийхээ дагуу хэрэглэгчид сонголт хийх боломжтой болно<br>▪ Сурах бичиг худалдан авахад зарцуулах төрийн ачаалал буурна.<br>▪ Сурах бичиг бүтээх хүний болон технологийн нөөцийн чадавхи нэмэгдэнэ.<br>▪ Сурах бичгүүд хувилбартай, чанартай багц болсон байна.<br>▪ Бүх мэргэжлийн багш бүр сургалтын цахим, хэвлэмэл хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангагдсан байна.<br>▪ Бага ангийн сурагчдын унших номоор сургуулийн номын сангийн хөмрөг баяжина |
| 2.8. Боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийх | 2.8.1. Бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай материаллаг орчны (ЕБС-ийн тавилга, тоног төхөөрөмж, кабинет, лабораторийн) стандарт боловсруулж, мөрдөх<br>2.8.2. Сургуулиудыг интернетэд холбох<br>2.8.3. Ангийн самбар, ширээ, сандлыг шинэчлэх<br>2.8.4. Сургуулиудыг цахим сургалтын тоног төхөөрөмжөөр тоноглосон анги танхимтай болгож, компьютер нийлүүлэх<br>2.8.5. Биеийн тамирын боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлж, холбогдох хэрэглэгдэхүүнээр сургуулиудыг хангах<br>2.8.6. Сургуулиудыг хөгжмийн боловсрол олгоход шаардагдах хэрэглэгдэхүүнээр хангах<br>2.8.7. Байгалийн ухааны лабораториудын стандартыг шинэчлэн хангамжийг нэмэгдүүлэх<br>2.8.8. Технологийн боловсрол олгоход шаардагдах хэрэглэгдэхүүнээр сургуулиудыг хангах | ▪ Сургалтын орчны шинэ стандарт мөрдөгдөнө.<br>▪ Сум дундын болон цогцолбор сургуулиудад интернетэд холбогдсон цахим сургалтын кабинетууд байгуулагдаж ашиглагдана.<br>▪ Сумдын сургуулиудад цахим сургалтын арга зүйг хэрэглэхэд шаардлагатай орчин нөхцөл бүрдэнэ.<br>▪ Бага ангийн хүүхэд бүр хөгжмийн нэг ижил зэмсэгтэйгээр хичээллэх боломж бүрдсэн байна.<br>▪ Бүх сургуульд биеийн тамирын тоног төхөөрөмжийг нийлүүлнэ<br>▪ Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний санхүүжилтийг жил бүр 8 хувиар нэмэгдүүлнэ.<br>▪ 2010 он гэхэд ахлах ангид 10 сурагчид, дунд ангид 104 сурагчид, бага ангид 520 сурагчид 1 компьютер ногдох болно |

*/Үргэлжлэл нь дараагийн дугаарт/*

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эрхлэл.
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 265958
Индекс: 14003
Хэвлэлийн хуудас 3.5
☎ 329487